



2020 САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН

MSE: ARD



Бидний улс эв саналыг нэгтгэн нийт нэгэн хүчнийг нийлүүлэн нэгэн зэргээр зориглон хөдөлбөл, үл хүрэх газаргүй бөгөөд мэдэхгүй, чадахгүй гэх явдал огт үгүй болж, гадаад дотоодын эзэрхэг савраас гарч, учрах зовлонгүй болж, цэнгэлийн манлайг олж болохыг дан ганц бидний сэтгэлийн чин зориг мэднэ. Ташаагүй үнэн болохыг би батлан өгүүлнэ.

Д. Сүхбаатар

Монголын тусгаар тогтнол эрх чөлөөний удирдагч

Агуулга

Гүйцэтгэх удирдлагын тайлан	6
Эрхэм зорилго	12
Алсын хараа	13
Гол үзүүлэлт	14
Компанийн тухай	16
2020 оны онцлох үйл явдал	18
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	20
Төлөөлөн Удирдах Зөвлөл	21
ТУЗ-ийн дарга	22
Ердийн гишүүд	23
Хараат бус гишүүд	28
Удирдлагын баг	32
Эдийн засгийн орчин	34
Мөнгө, санхүү	37
Хөрөнгийн зах зээл	38
Түүхий эдийн зах зээл	41
Валютын зах зээл	43
Криптовалютын зах зээд	44
Гүйцэтгэлийн тайлан	46
Маркетинг	46
Хүний нөөц	49
Технологи	51
Хөрөнгө Оруулалт	53
Үл Хөдлөх Хөрөнгө	56
Монголын Хөрөнгийн Биржийн Арилжаа	56
Санхүүгийн гүйцэтгэл	57

Хөрөнгө оруулалтын багц	60
Ард Даатгал	62
Ард Кредит	66
Ард Секюритиз	70
Ард Лайф	74
Ард Актив	76
Ард Менежмент	78
Ард Бит	80
АрдШоп	82
DAX – Виртуал Хөрөнгийн Бирж	84
Үндэсний Хувьчлалын Сан	85
Монгол Шуудан	86
Бидний ойрын ирээдүй	88
2021 оны эхний улирлын гол үйл явдал	90
Үнэлгээ	92
Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа	93
Хараат бус аудитын тайлан	94
Санхүүгийн байдлын тайлан	95
Орлогын дэлгэрэнгүй тайлан	97
Өмчийн өөрчлөлтийн тайлан	98
Мөнгөн гүйлгээний тайлан	99

Гүйцэтгэх удирдлагын тайлан

Сайн байна уу, сайн сууж байна уу, та?

Уламжлал ёсоор шинээр гарсан Цөөвөр хэмээх Цагаагчин Үхэр жилийн эхний улиралд Компанийнхаа жилийн тайланг, хувьцаа эзэмшигч танд хүргэнгээ мэндчилж байгаадаа баяртай байна.

Өнгөрөгч 2020 онд дэлхий даяар коронавирусын цар тахал дэгдсэний улмаас улсын хил хаагдаж, бүх нийтээрээ хөл хорионд орж, төрөөс онцгой дэглэмд шилжин бид бүхний сурсан, дассан бүх зүйл өөрчлөгдөж, амьдралын хэв маяг, нийгмийн харилцаа орвонгоороо эргэсэн урд өмнө тохиолдож байгаагүй онцгой үйл явдлуудаар дүүрэн жил боллоо. Төр засгаас иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, орлогын эх үүсвэрийг тасалдуулахгүй байх тал дээр анхаарч ажилласан ч ард иргэдийн хувьд ч, бизнесийн байгууллагуудын хувьд ч онцгой хүнд нөхцөл байдалд ажил, амьдралаа залгуулан ажиллалаа. Олон ч компани зах зээл, хэрэглэгчгүй болсон тул үүд хаалгаа барьж, ажилчдаа цомхотгон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ таг зогсоох байдалд хүрсэн харамсалтай дүр зураг нийтлэг байв.

Харин Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөний гишүүн таны хөрөнгө оруулж, хамтдаа байдаг Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд бүхий л ажлаа эртнээс цахимжуулж, салбаргүй, цомхон чадварлаг бүтэцтэй ажиллаж ирсний хувьд өнгөрсөн жил нийтлэг хандлагыг сөрөн зах зээл дээрх байр сууриа өсгөж, тэлсэн, олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, нэвтрүүлсэн, ололт амжилтаар богцоо дүүргэсэн он жил боллоо. Манай хувьцаа эзэмшигчид

хуулинд заасан хугацаанд хурлаа цахимаар зохион байгуулсан бол хил хаагдсаны улмаас миний бие гадаадад гацсан цаг хугацаагаа ашигтайгаар эргүүлж, Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох зорилгынхоо хүрээнд гэр бүлийнхээ хамтаар Европод, харин манай багийнхан Монгол даяар бүтээгдэхүүн үйлчилгээгээ таниулан сурталчилж, шинэ хэрэглэгчдийг олноор татаж чадлаа.

Монголын хамгийн анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан IPO-гоо амжилттайгаар хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэв. Манай баг Ард Аппын 4 дэхь хувилбарыг боловсруулан Digital Assets Exchange буюу Виртуал Хөрөнгийн Бирж (DAX.mn) болох блокчэйн технологид суурилсан крипто, секюрити токен арилжаалах платформоо олон нийтэд танилцуулж эхэллээ. Монгол Шуудантай хамтран бид EuroGiro хэмээх олон улсын мөнгөн гуйвуулгын сүлжээний үйлчилгээг нэвтрүүлж эхлэв. Олон жилийн хугацаанд төлөвлөгдсөн Монгол ТВ-ийн Аппрентис Монгол Шоу олны хүртээл болсон бөгөөд гарсан өдрөөсөө эхлэн үзэгч түмний таашаалд нийцэж, бизнесийн менежмент, маркетинг, санхүүгийн боловсролыг түгээхэд их ач холбогдолтой нэвтрүүлэг боллоо.

2020 оны эхэнд Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексийн сагс шинэчлэгдэж, Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хөрөнгө оруулалттай 3 компани багтсан юм. Тус индекс нь өмнөх ондоо хамгийн ихээр арилжаалагдсан компанийн хувьцааг онцгойлдог үзүүлэлт билээ.



Ард Санхүүгийн Нэгдэл (AARD), Ард Даатгал (AIC), Ард Кредит (ADB), Ард Лайф ХХК, Ард Актив ХЗХ, Үндэсний Хувьчлалын Сан (ХОС) 2021 оны 1 сарын 22-нд санхүү, үйл ажиллагааны тайлангаа урьдчилсан байдлаар хөрөнгө оруулагчиддаа танилцуулсан билээ. Ард Холдингс тайлант хугацаанд 200 сая, Ард Даатгал 2.1 тэрбум, Ард Кредит 2.1 тэрбум төгрөгийн нийт ашигтай тус тус ажиллалаа. Ард Кредитын хувьд 467.77 мянган ширхэг зээлийн хүсэлт хүлээн авснаас 48.6 мянган зээлдэгчдэд 42.1 тэрбум төгрөгийн зээл олгож ажилласан байна. Харин Ард Даатгалын нийт хөрөнгө 28.7 тэрбум төгрөгт хүрч, 15.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэн ажиллалаа. Ард Лайфын харилцагчдын тоо 10,000-ын босгыг даван, хөрөнгө оруулалтын ашиг өмнө жилийнхээс 63 хувиар өсч 1.6 тэрбум төгрөг болсон байна. Ард Активын хөрөнгө 66 хувиар өсч 6.9 тэрбумд хүрсэн бол Үндэсний Хувьчлалын Сан нь ард иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа эхлүүлэн оны эцэст хөрөнгө оруулагчиддаа жилийн 25.6 хувийн өгөөжтэй ажиллаж чадсан байна. Гараа сайн бол бариа сайн гэдэг. Оны сүүлчээр Ард Апп хэрэглэгчдийн тоо 637 мянга болж, 202 сая ширхэг АрдКойн урамшууллаар олгогдсон байна. АрдШопын стратегийг шинэчлэх үйл явц эрчимтэй өрнөж, хөл хорионы үед харин ч бизнесээ Монгол Шуудангийн хамтаар эрчимжүүлээд авсныг дурдах хэрэгтэй болов уу?

Ковидын цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа тасалдах эрсдэлтэй энэ үед Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хөрөнгө оруулалттай компаниуд ногдол ашиг тараасан нь

сонин содон бизнесийн шийдэл байсан бөгөөд Ард Кредит 1.1 тэрбум, Ард Даатгал 850 сая, Ард Санхүүгийн Нэгдэл 1 тэрбум төгрөгийг тус бүр хувьцаа эзэмшигчидтэйгээ хуваалцсан юм. Хүчтэй бөгөөд Хамтдаа байх уриандаа үнэнч байсныг энэ маань илтгэж байгаа болов уу? Итгэл хүлээлгэсэн та бүхэндээ баярлалаа!

Ард Академи ард иргэдийнхээ санхүүгийн боловсрол, бизнесийн мэдлэгийг тогтмол нэмэх зорилгынхоо хүрээнд харилцагч, хэрэглэгчдэдээ 7 хоног бүр хувийн санхүү, хөрөнгө оруулалт болон менежментийн сэдвийн хүрээнд мэргэжлийн хүмүүсээс ярилцлага авч, нийтлэл бэлтгэн хүргэхээс гадна цахим сургалт зохион байгуулж ирлээ. Бид одоогийн байдлаар нийт 38 удаа сургалтыг цахимаар болон танхимаар хийж, вэбсайтдаа нийт 136 нийтлэл оруулсан байгаа бол хэрэглэгчдийн зүгээс 125,862 удаа орж уншихдаа 2,387 цаг зарцуулжээ.

Ард Санхүүгийн Нэгдэл нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Улаанбаатар–Сонгдо” эмнэлгээс хэрэгжүүлсэн “Зүрх мартахгүй” төсөл, УОК-т дэмжлэг үзүүлэхээр МББСБХ-ноос санаачилсан хандивын аян зэргийг дэмжиж мөнгөн хандив өргөж оролцсон бол төр засгаас хэрэгжүүлсэн ажлын байрыг цөөлөх бус тогтвортой хадгалах бодлогыг дэмжиж, хэрэгжүүлж ажилласан болно. Манай бүх компаниуд татвар, шимтгэлээ цагт нь зөв тодорхойлж, төлж ажилладгаараа улсынхаа төсвийг бүрдүүлэхэд жил ирэх тусам улам том хувь нэмэр болж байгааг онцлох нь зүйтэй болов уу?

Ажил хийвэл ам тосдоно гэдэг – манай хувьцааны үнэ он гарсаар Монголын Хөрөнгийн Биржийн хамгийн өндөр өсөлтийг үзүүлж, 3 мянган төгрөгийн босгыг анх удаагаа давлаа. АрдКойны үнэ ханш ч өсөж 30 төгрөгт хүрсэн нь бидэнд итгэж, бидэнтэй хамт олон жилийн туршид хүлээцтэй байсан та бүхэнд миний амлалт биеллээ олно, бид зөв зүг чигт явж байгаа гэдэг итгэлийг тань бататгасан болов уу? Энэ бол зөвхөн эхлэл гэдгийг санаарай – бид бүх Монголчууд хөрөнгө оруулагч болж, мөнгөө өөрийнхөө төлөө ажиллуулдаг болсноор санхүүгийн эрх чөлөөнд хүрч, өрх бүр орлого, амьжиргааны олон давхар хөдөлгүүртэй болох ёстой гэдэгт итгэдэг.

Үүнийгээ ч гүйцэлдүүлнэ гэж зүтгүүлдэг. Миний та бүхэндээ захиж хэлэх зүйл энгийн – АвДар.

2021 онд бид банкинд хөрөнгө оруулалт хийх болно. Нээлттэй хөрөнгө оруулалтын сантай болно. Тэтгэврийн шинэчлэлээ зүтгүүлнэ. Кредит картаа гаргана. Манай даатгалын үйлчилгээ бүрэн цахимжина. Цахим биржээ төгөлдөршүүлнэ.

АрдКойныхоо хэрэглээг нэмэгдүүлнэ. Манай хэрэглэгчид 1 саяд хүрэх болно гэж тооцоолж байна. Бид хамтдаа гадаадын бирж дээр гарах болно. Та итгэлтэй байж болно. Би хэлсэн бол хийдэг. Энд одоогоор зарлаж болохгүй нилээд хэдэн ажил бас бий гэдгийг онцлон цохъё.

Мэдээжийн хэрэг ажил хийж байгаа юм чинь алдах тохиолдол гардаг аа. Замд давж туулшгүй мэт саад бэрхшээл тулгардаг. Хөндлөнгөөс ч дайрах болно. Гэхдээ бид хийж байгаа зүйлдээ төгс итгэлтэй байдаг учир бүх хүндрэл бэрхшээлийг ажралгүй даван туулсаар ирсэн. Бидний сэтгэл зүрхэнд гал дүрэлзэж байгаа цагт бүхий л асуудлыг даван туулаад л явах болно. Үнэн ямагт ялдаг. Бидний Ард Монгол юм.


2021 оны Цөөвөр Үхэр жил айсуй. Миний хувьд хөрөнгийн зах дээр Бух давхилаа гэж харж байгаа. Танд амжилт, аз жаргалыг хүсье! Мөнгөө өөрийнхөө төлөө ажиллуулах үйлсэд тань амжилт хүсье! Чоно шиг хийморьтой байгаарай!

Хүчтэй. Хамтдаа.

Гүнээ хүндэтгэж, мэхийн ёсолсон, Ард Санхүүгийн Нэгдлийн Үүсгэн Байгуулагч, танай

Гүйцэтгэх Захирал

Хутагт овогтой Чулууны Ганхуяг

The background of the slide is a solid red color. On the left side, there are three stylized white mountain peaks of varying heights and widths, creating a jagged silhouette. The peaks are positioned such that they appear to be part of a larger landscape. The text is located on the right side of the slide, to the right of the mountain peaks.

Жич: Энэхүү жилийн тайланг бичиж, санхүүгийн тайлангийн аудит хийгдэх зуур буюу 2021 оны эхний улиралд Ард Санхүүгийн Нэгдлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, ирээдүйн төлөвт асар том өөрчлөлтүүд гарсан бөгөөд манай санхүүгийн нөхцөл байдлыг өмнөх оны тайлангаар дүгнэх боломжгүй болсонтой холбоотойгоор 2020 оны жилийн тайландаа бид 2021 оны эхний улирлын үзүүлэлтүүдийг оруулахаар шийдвэрлэсэн болно.

Эрхэм зорилго

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно.



Алсын хараа

Бүс нутагтаа тэргүүлэгч финтек нэгдэл болох.

Мөрдөх зарчим

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана;
- Ёс зүйн хэм хэмжээг өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөхийн зэрэгцээ хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллана;
- Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллана;
- Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэн ажиллана;
- Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрмэлзэнэ;
- Шинийг нэвтрүүлж, манлайлах бодлогыг мөрдөж ажиллана;

- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө;
- Хамгийн авьяаслаг, хүчирхэг, мэргэжлийн, цомхон, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж ажиллах бөгөөд шинээр ажилд орох босгыг өндөрт тогтоож, ажлын байранд тавигдах шаардлага, хариуцлагыг чанд мөрдөнө;
- Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлж ажиллана;
- Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана;
- Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах шилдэг стандартыг нэвтрүүлж ажиллана;
- Бүтээгдэхүүн үйлчилгээндээ өөрсдийн итгэл үнэмшил, философийг шингээж ажиллана.

Давуу шинж чанар

- Өрсөлдөх чадвар, үр ашиг болон дэвшилтэт технологийг цогцлуулсан түншлэл;
- Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал;
- Шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч олон улсад танигдсан хамт олон;
- Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж;
- Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэн болгох туршлага;
- Хөрөнгө оруулагч үндэстний танигдсан брэнд;
- Үндэсний хэмжээний цогц дэд бүтэц;
- Энтрепренёр соёл.

Гол үзүүлэлт (тусдаа тайлан)

(Сая төгрөгөөр)	2019	2020	Жилийн өөрчлөлт	2021 У1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43	101	133.50%	616
Дансны болон бусад авлага	4,919	1,687	-65.69%	11,482
Үндсэн хөрөнгө	642	906	-27.41%	493
Биет бус хөрөнгө	3,262	8,941	174.14%	149,479
Урт хугацаат хөрөнгө оруулалт	68,238	67,481	-1.11%	268,000
Нийт хөрөнгө	78,072	80,380	2.96%	437,025
Богино хугацаат өр төлбөр	3,736	18,007	381.97%	16,182
Урт хугацаат өр төлбөр	17,753	6,540	-63.16%	44,065
Өр төлбөрийн нийт дүн	21,489	24,548	14.23%	60,246
Эздийн өмчийн дүн	56,582	55,832	-1.33%	376,779
Нийт орлого	2,854	3,780	32.44%	19,588
Нийт зардал	7,292	7,117	-2.38%	2,935
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-4,576	-4,035	11.83%	14,551
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн	10,024	4,235	-57.75%	289,672
Нийт дэлгэрэнгүй ашиг	5,448	200	-96.32%	304,223
Нийт үнэлгээ	59,653	59,237	-0.70%	408,212
Гаргасан хувьцааны тоо (ширхэг)	27,175,629	28,614,263	5.29%	28,614,263
Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)	2,195	2,070	-5.69%	14,266

Санхүүгийн харьцаа үзүүлэлт (тусдаа тайлан)

(Сая төгрөгөөр)	2019	2020	Жилийн өөрчлөлт	2021 У1
Хөрөнгө оруулалт/Нийт Хөрөнгө	87.40%	83.95%	-3.45%	61.32%
Хөрөнгө оруулалт/Өөрийн хөрөнгө	120.60%	120.86%	0.26%	71.32%
Өр төлбөр/Нийт Хөрөнгө	27.53%	30.54%	3.01%	13.79%
Санхүүгийн зардал/Нийт зардал	19.94%	40.41%	20.47%	23.94%
Санхүүгийн зардал/Нийт өр, төлбөр	9.25%	12.49%	3.24%	1.66%
Үйл ажиллагааны зардал/Нийт зардал	64.27%	37.78%	-26.49%	55.43%
Үйл ажиллагааны зардал/Нийт Хөрөнгө	6.00%	3.34%	-3.34%	0.37%
Цалингийн зардал/Нийт зардал	15.78%	21.80%	6.02%	20.61%
Цалингийн зардал/Нийт орлого	41.31%	49.97%	8.66%	3.09%

Нэгтгэсэн үзүүлэлт

	2019	2020	Жилийн өөрчлөлт	2021 У1
Нийт компани	19	20	5.26%	21
Нэгтгэсэн нийт хөрөнгө (сая)	89,068	114,748	28.83%	528,440
Нэгтгэсэн дэлгэрэнгүй ашиг (сая)	4,074	1,605	-60.60%	363,718
Нийт ажиллагсад	199	223	12.06%	276
Хувьцаа эзэмшигч	7,183	12,296	71.18%	57,940
Ард Апп хэрэглэгч	334,501	637,000	90.43%	1,189,000
АрдКойн эзэмшигч	155,000	286,117	84.59%	668,312
Даатгуулагч	135,191	166,509	23.17%	226,394
Зээлдэгч	32,578	37,694	15.70%	40,324
Тэтгэврийн данс эзэмшигч	1,210	10,500	767.77%	25,000
Үнэт цаасны данс эзэмшигч	83,047	89,305	7.54%	120,350

Компанийн тухай



Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Кор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсдад зориулан 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-ГЭ ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-ГЭ ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэгдэл болж өргөжсөн юм.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь ХасБанкны үүсгэн байгуулагч, одоогийн Гүйцэтгэх Захирал Ч.Ганхуягийн санаачилгаар 2005 оны 9 сард Employee Investment Trust буюу И Ай Ти ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурь ийнхүү тавигдсан түүхтэй.

И Ай Ти нь үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 12,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй, 80 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна. 2013 онд манай гол хувьцаа эзэмшигчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан юм. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд бид Ард Кредит, Ард Даатгал, Ард Секюритиз, Ард Лайф болон Ард Активд тасралтгүй хөрөнгө оруулж эхэлсэн билээ.

2016 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч болж чадсан юм. 2017 онд манай үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын сангийн удирдлагыг хэрэгжүүлэх Ард Менежмент, блокчэйн болон криптовалютын чиглэлээр ажиллах Ард Бит компаниуд нэмэгдсэн байна. 2018 оноос ТэнГэр Системс компани өөрийн үйл ажиллагааны чиглэлд шинэчлэлт хийж, блокчэйн технологи руу шилжиж эхлэв. 2019 онд Ард Пропертиз, Ард Риэл Эстейт, Ард Лизинг, Ард Холдингс Интернэшнл, Ард Бит зэрэг компаниуд байгуулагдаж, нэгдлийн бүтцэд багтаж эхлэв.

Бид хүн бүр бүтээсэн баялгаасаа хувь хүртэх ёстой, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ хөтлөгдөн 2015 онд Ард Холдингсыг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Жинст-Увс нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэж Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн бол 2019 оны 8 сарын 8-нд Ард Санхүүгийн Нэгдэл RTO хийснээр нээлттэй хувьцаат компани болсон юм. 2020 онд Монголын анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан үйл ажиллагаагаа амжилттай явуулж эхэлсэн бол Виртуал Хөрөнгийн Бирж болох DAX мөн онд олон түмэнд үйлчилгээгээ хүргэж эхлэв.

2020 оны онцлох үйл явдал



1 сарын 13

Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексн сагс шинэчлэгдэж, Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит болон Монгол Шуудан компаниуд багтав.

2 сарын 12

Ард Секюритиз ҮЦК Гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авав.

2 сарын 19

Ард Санхүүгийн Нэгдэл нийт ашгаасаа 12.65 хувь буюу 1 тэрбум, Ард Даатгал 49.45 хувь буюу 850 сая, Ард Кредит 50 хувь буюу 1.18 тэрбум төгрөгийг тус тус ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэв.

4 сарын 1

Ард Лайфад нэмэлт хөрөнгө оруулалт хийв.

4 сарын 27

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа анх удаа цахимаар амжилттай зохион байгуулав.

5 сарын 5

АрдКойн Монголын хамгийн анхны олон улсын крипто бирж болох BitMonex-д бүртгэгдэв.

5 сарын 20

Ард Кредит ХК Монголбанкнаас АрдКэш цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авснаар банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв.

5 сарын 25

Ирээдүйн Эзэд – Хувьцаатай Хүүхэд аян эхлэв.

6 сарын 10

Ард Менежмент үнэт цаасны компанийн санаачилгаар байгуулагдсан Үндэсний Хувьчлалын Сан Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл авав.

6 сарын 11

Хөрөнгө Оруулагч Үндэстэн аяны хүрээнд Европын холбооны улсууд болон 21 аймгаар тойрон мэдээлэл хүргүүлэх сургалт, танилцуулгаа эхлүүлэв.

6 сарын 19

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт байдлаар явуулж нэмэлт өөрчлөлтийг батлав.

10 сарын 2

Ард Кредит Монгол Шуудантай хамтарсан ЕвроЖайро олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний нээлтээ хийв.

10 сарын 5

Ард Менежмент Үндэсний Хувьчлалын Сан нэртэй Монголын анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг нээж, Монголын Хөрөнгийн Бирж дээр цан цохив.

12 сарын 13

Ард Санхүүгийн Нэгдэл, Монгол ТВ хамтран Дэлхийн алдарт бизнесийн нэвтрүүлэг Аппрентис шоуг Монголд хийж, анхны дугаар цацагдав.

12 сарын 14

Ард Кредит АСН+ (Automated Clearing House) банк хоорондын жижиг төлбөр тооцооны системд нэгдэв.

Виртуал Хөрөнгийн Бирж (DAX) туршилтын журмаар үйл ажиллагаагаа эхлүүлэв.

12 сарын 16

Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг Степ Голд нь Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа давхар бүртгүүлэхээр болж, андеррайтераар Ард Секюритизыг сонгон ажиллахаар болов.

12 сарын 26

Крипто Үндэстэн Сан нь үйл ажиллагаа эхлүүлээд 3 жилийн дараа 110 хувийн өгөөжтэй хаагдав.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигч		2019	Хувь	2020	Хувь	2021 У1	Хувь
1	Ард Бит	4,243,090	14.8%	3,934,898	13.8%		
2	Ард Холдингс Интернэшнл	2,874,410	10.0%	2,874,410	10.0%	1,300,000	4.5%
3	Хишигдорж Батхишиг	2,657,214	9.3%	2,657,214	9.3%	2,658,444	9.3%
4	Бруно Рашле	2,074,922	7.3%	2,098,592	7.3%	2,104,592	7.4%
5	Ард Лайф	1,365,018	4.8%	1,565,288	5.5%	1,842,279	6.4%
6	Галням Уянга	1,330,147	4.6%	1,333,147	4.7%	1,346,936	4.7%
7	Чулуун Ганхуяг	1,239,374	4.3%	1,264,519	4.4%	1,340,364	4.7%
8	Ард Секюритиз	1,007,392	3.5%	1,033,080	3.6%	761,126	2.7%
9	И Ай Ти	331,253	1.2%	733,349	2.6%	4,547,305	15.9%
10	Авир Сүхдорж	536,417	1.9%	563,155	2.0%	568,266	2.0%
11	Ронк Лимитэд	479,111	1.7%	479,111	1.7%	479,111	1.7%
12	Сэдбазар Гэрэлтуяа	455,717	1.6%	455,717	1.6%	455,935	1.6%
13	Ард Даатгал	435,362	1.5%	417,905	1.5%	411,455	1.4%
14	Далхаа Отгонбаяр			331,254	1.2%	233,303	0.8%
15	Лхагвасүрэн Соронзонболд	315,069	1.1%	271,542	0.9%	199,086	0.7%
Топ хувьцаа эзэмшигчид		19,344,496	71.2%	20,013,181	69.9%	18,248,202	63.8%
Бусад хувьцаа эзэмшигчид		7,831,133	28.8%	7,186,376	25.1%	10,366,061	36.2%
Эргэлтэнд байгаа хувьцаа		27,199,557	95.0%	27,199,557	95.0%	28,614,263	100.0%
Халаасны хувьцаа		1,414,706	5.0%	1,414,706	5.0%	0	0.0%
Хувьцаа эзэмшигчдийн тоо		4,063		4,523		13,730	

Энэхүү үзүүлэлтийг бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөл



Хувьцаа эзэмшигч		AIC		AARD		ADB		MNP	
		2020	2021 У1	2020	2021 У1	2020	2021 У1	2020	2021 У1
1	Чулуун Ганхуяг	9,561	56,454	1,264,519	1,340,364	714,785	884,885	11,708	11,762
2	Пүрэвжаргал Батбаяр	70,586	70,586	88,008	98,603				
3	Бруно Рашле	25,591	25,591	2,098,592	2,104,592				
4	Мөнх-Очир Сэргэлэн	17,407	17,407	56,432	62,635				
5	Одончимэд Одбаяр				7,091				
6	Авир Сүхдорж	149,749	149,749	563,155	568,266	5,086,580	5,086,580		
7	Чулуун Мөнхбат	16,342	16,342	29,686	36,786				
8	Михаил Зелдович								
9	Майнбаяр Тулгат		1,000		1,000	39,682	50,000		
10	Арно Вентура			7,903	13,923				

ТУЗ-ийн дарга



Пүрэвжаргалын **Батбаяр**

(ТУЗ-ийн дарга, Ард Санхүүгийн Нэгдэл)

ИБУИНВУ-ын Свонси хотын Уэлсийн их сургуулийг Эдийн засгийн бакалаврын зэрэгтэйгээр, Лондонгийн Бизнесийн Сургуулийг мастерын зэрэгтэйгээр тус тус амжилттай дүүргэсэн П.Батбаяр нь 20 жилийн хугацаанд Лондон болон Улаанбаатар хотод банк, санхүүгийн салбарт ажиллан туршлага хуримтлуулсан нэгэн юм. Тэрээр ЕСБХБ-нд 10 орчим жил ажиллахдаа Монгол Улсад уул уурхай, нефтийн хөрөнгө оруулалтын төслүүд хариуцсан төлөөлөгчөөр, мөн Зүүн Европ, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд болон Монголыг хамарсан уул уурхай, газрын тосны салбар дахь томоохон хэд хэдэн шинэ төслүүдийг судалж, санхүүжилтийн гэрээ хэлцэл байгуулах, хэрэгжүүлэх ажлыг гардан гүйцэтгэсэн. Түүний урьд нь гүйцэтгэж байсан бусад ажлуудаас дурдвал, Монгол Улсын

тэргүүлэх арилжааны банкны нэг Хаан Банк, худалдаа, үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч Интергрупп ХХК болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг Олова ХХК-д тус тус удирдах алба хашсан.

П.Батбаяр нь уул уурхайн зөвлөгөө, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг RMM Pty Ltd компанийн ТУЗ-ийн гишүүн, Монголын Рагбигийн Холбооны ТУЗ-ийн гишүүнээр давхар ажиллаж байна. 2014 оны 1 сараас Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, 2017 оны 8 сараас ТУЗ-ийн даргаар тус тус томилогдсон.

Ердийн гишүүд



Чулууны **Ганхуяг**

(Гүйцэтгэх захирал, Ард Санхүүгийн Нэгдэл)

Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэсэн тэрээр Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан Гүйцэтгэх захирлаар томилогдсон юм.

ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан юм. Ч.Ганхуяг нь ХасБанк байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх

захирал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдаар тус тус ажиллаж байв. Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн УЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн байна. Мөн Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчийн сонгуульт ажлыг давхар хашдаг. Ч.Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Ердийн гишүүд



Бруно Рашле

(Дэд дарга, Шродер Адвек)

Швейцарын Холбооны Технологийн Институтыг барилгын инженерийн чиглэлээр, Стэнфордын их сургуулийн аж үйлдвэрийн инженер мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн бөгөөд 1990 онд Харвардын Их Сургуульд дэвшилтэт менежментийн хөтөлбөрийг дүүргэсэн Бруно Рашле 1997 онд Адвек Группыг үүсгэн байгуулж, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад 2017 онд компаниа Шродер Группд худалдсан байна. Шродер Адвек нь хувийн хөрөнгө оруулалтын менежментийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Тус компани нь харилцагч санхүүгийн

байгууллагуудаас хуримтлуулсан 10 гаруй тэрбум долларын санг удирдаж, дэлхийн хэмжээнд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байна.

Адвекыг үүсгэн байгуулахаас өмнө Бруно Рашле нь Швейцарийн Мотор-Колумбусын сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ЭмСи Партнерс сангийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ. Тэрээр 5 тивд байрлах төрөл бүрийн аж үйлдвэрүүдийн төслийг эхлүүлэх, нэмэлт хөрөнгө оруулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төсөл хөтөлбөрийг удирдсан туршлагатай.



Авирын Сүхдорж

(БСБ Сервис, ГрэйпСити Монгол, МОСТ Финтек компаниудын үүсгэн байгуулагч)

ГрэйпСити Монгол ХХК, Мост Финтек ХХК-ийн ТУЗ-ийн дарга Украин улсын Киев хотын Политехникийн их сургуулийг Компьютерийн инженер мэргэжлээр төгссөн А.Сүхдорж нь 1975 оноос Улсын Төлөвлөгөөний комиссоос ажлын гараагаа эхэлж төд удалгүй Монгол Улсын төв банкны Тооцоолон Бодох төвийн даргаар томилогдон ажиллаж байжээ.

Социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэний дараахан 1991 онд Монгол Улсын анхны мэдээллийн технологийн компани болох БСБ группыг үүсгэн байгуулсан байна. БСБ Группын ТУЗ-ийн дарга, ерөнхий захирлаар ажиллаж байх хугацаандаа 2000 онд банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн компани болох ГрэйпСити Монгол ХХК-ийг үүсгэн байгуулж,

2001 онд сансрын холбооны үйлчилгээ үзүүлэгч Инкомнет ХХК-ийг байгуулсан юм. ГрэйпСити Монгол нь эдүгээ Монгол Улсын банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн тэргүүлэгч компани болжээ.

Тэрээр Монголын Мэдээлэл Харилцаа Холбооны хөгжлийн түүчээлэгч бөгөөд банк санхүү, төлбөрийн секторын хөдөлгөгч хүч болсоор ирсэн билээ. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд олон тооны амжилттай төслүүд хэрэгжүүлсэн бөгөөд 2008 онд улсын хэмжээний анхны төлбөрийн үйлчилгээний оператор компанийг байгуулж (Мост Финтек ХХК), 2012 онд цахим төлбөр тооцооны МостМони мобайл хэтэвч үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.

Ердийн гишүүд



Одончимэдийн **Одбаяр**
(ТУЗ-ийн гишүүн, Ард Даатгал ХК)

Зөвлөлт Холбоот Улсын Киев хотын Багшийн Их Сургуульд багш мэргэжлээр суралцаж, Монгол Улсын магистр зэрэгтэй, АНУ-ын Флорида мужийн Техникийн Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд олон улсын эдийн засагч мэргэжлээр, 1997-2000 оны хооронд Отгонтэнгэр Их Сургуульд хуульч, эрх зүйч мэргэжлээр, 2017 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуульд удирдлагын чиглэлээр суралцаж төгссөн.

О.Одбаяр нь Монгол Хятадын хамтарсан Төрийн Өмчит Улсын Үйлдвэрийн Газрын захираллаар, Монгол Улсаас БНХАУ-д суугаа

ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Алтай Холдинг ХХК-ийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байгаад 2016 оноос Төрийн өмчит Эрдэнэс Монгол компанийн ын Бизнес хөгжлийн асуудал эрхэлсэн Дэд захирлын албыг хашиж, төрийн өмчит аж ахуйн нэгж, стратегийн ач холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгийг олборлох, боловсруулах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдийг удирдан түүний үр өгөөжийг баялгийн сангаар дамжуулан Монгол Улсын нийт ард иргэдэд хүртээх ажлыг хийж гүйцэтгэжээ.



Майнбаярын **Тулгат**
(Дэд захирал, Хишиг Арвин Индустриал)

Япон улсын Киото их сургуулийн Эдийн засгийн факультет, Эдийн засгийн ухааны бакалавр зэргийг дүүргэж, магистрын зэрэг хамгаалсан М.Тулгат нь 2013 оноос Хишиг Арвин Индустриал ХХК-ийн менежерээр ажиллаж эхэлсэн бол одоо Дэд захирлаар ажиллаж байна.

Ажлын гараагаа Япон улсын Софтбанк ХК-д бизнес төлөвлөлтийн хэлтэст ажилтнааср эхэлорж, 2005-аас 2009 он хүртэл ажилласан бол, 2009-2013 онд Бэкфорс ХХК-ийн Еерөнхий захирлаар ажиллаж байсан туршлагатай. Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн Ердийн гишүүнээр 2020 оны 5 сараас эхлэн ажилласан.

Хараат бус гишүүд



Чулууны **Мөнхбат**

(Ерөнхийлөгч, Саусгоби Сэндс)

ОХУ-ын Ленинград хотын дээд сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн ба Монгол Улсын Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистр, Шинэ Зеланд Улсын Вайкато их сургуульд Төрийн бодлого, удирдлагын чиглэлийн магистрын зэрэг хамгаалсан Ч.Мөнхбат нь Саусгоби Сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлаар 2015 оны 9 сарын 7-ны өдрөөс томилогдон ажиллаж байна.

Ажлын гараагаа Саусгоби Ресурс компанид Зөвлөхөөр ажиллаж эхэлсэн бөгөөд улмаар Саусгоби сэндс ХХК-ийн Засгийн газрын харилцаа, Бодлогын хэрэгжилт хариуцсан захирлаар ажиллаж байв. Үүний өмнө тэрбээр Азийн Хөгжлийн Банкинд Төслийн захирлаар, Дэлхийн Банкинд Зохицуулагчаар тус тус ажиллаж байв. Ч.Мөнхбат нь Шинэ Зеланд Улсын Монгол Улс дахь Өргөмжит консул юм.



Мөнх-Очирын **Сэргэлэн**

(Гадаад харилцаа эрхэлсэн захирал, Техник Технологийн ДС)

Япон улсын Исити коллежийг менежментийн чиглэлээр, Бизнес, олон улсын дээд сургуулийг нягтлан бодогчоор тус тус төгссөн М.Сэргэлэн нь Техник Технологийн Дээд сургуулийн Ерөнхийлөгч, Монгол Коосэн Коллежийн захирлаар тус тус ажиллаж байна.

Тэрээр TCI компанийн захирал, MAC компанийн захирлаар тус тус ажиллаж байв. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат гишүүнээр 2018 оны 5 сараас ажиллаж эхлэв.

Хараат бус гишүүд



Михаил Зелдович

(Хяналтын зөвлөлийн дарга, Кокуун капитал)

Харвардын Хуулийн сургууль болон Флетчерийн Хууль, Дипломатын сургууль төгссөн Михаил Зелдович хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийх, худалдааны хэлэлцээр хийх, зөвлөгөө өгөх, ТУЗ удирдсан 20 гаруй жилийн туршлагатай мэргэшсэн хөрөнгө оруулагч бөгөөд түүхий эдийн арилжаа эрхлэгч юм. Тэрээр 2.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтын сангийн менежерээр ажиллаж байсан ба Бостон Консалтинг Группын зөвлөх, АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын худалдааны хэлэлцэгчээр тус тус ажиллаж байсан.

Одоогоор Михаил Зелдович нь Зүүн Өмнөд Азийн үр тарианы хөрөнгө оруулалтын сан Кокуун Капиталын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа ба ногоон технологи, хөдөө аж ахуйн технологи, цахим аюулгүй байдал, байгалийн баялгийн салбарт бие даан хөрөнгө оруулдаг.

Мөн дэлхийн зах зээл дээр түүхий эд арилжаалагч Трафикура компанийн бүс нутгийн тэргүүнээр 10 гаруй жил ажиллаж байна. Монгол Улсын эрчим хүчний хараат бус байдалд оруулсан хувь нэмрийг нь төрөөс өндрөөр үнэлж, түүнийг Алтан гадас одонгоор шагнажээ.



Арно Вентура

(Удирдах партнер, Гожо энд Компани)

Арно Вентура нь бичил, жижиг бизнесүүд рүү чиглэсэн, Африк тив, Хятад улсад тэргүүлэгч дижитал бичил санхүүгийн групп болох Баобаб Группын үүсгэн байгуулагч билээ.

Баобабын эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдэдээ энгийн, амар хялбар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний боломж бололцоог нээхэд туслах явдал юм. 2005 онд МикроКред нэртэйгээр үүсгэн байгуулагдсан тус компани нь 2018 онд 1 тэрбум евротой тэнцэх санхүүжилтийг цахимаар болон мянга гаруй салбар, үйлчилгээний цэгүүдээрээ дамжуулан олгосон.

Баобаб нь Африк, Хятадад үйл ажиллагаагаа явуулдаг 4,000 гаруй ажилтантай бөгөөд 1 сая орчим харилцагчтай.

Баобабыг үүсгэн байгуулахаас өмнө Арно Вентура нь Планет Финанс гэх олон улсын

хөгжлийн болон бичил санхүүгийн салбарт тэргүүлэх олон улсын байгууллагыг үүсгэн байгуулахын сацуу Позитив Экономик Форум хэмээх нийгэмд чиглэсэн Европын томоохон чуулга уулзалтыг санаачлан, хамтран зохион байгуулж байсан.

Арно 2005 онд Францын Залуу удирдагчаар, 2013 онд Дэлхийн эдийн засгийн форумаас Дэлхийн залуу удирдагчаар тус тус нэрлэгдсэн байна.

Планет Финансыг үүсгэн байгуулахаасаа өмнө тэрээр Франц, Аргентинд БНП Парибас банкинд ажиллаж байсан бөгөөд Франц, Тайландад тэргүүлэх интернетийн үйлчилгээг ханган нийлүүлэгч компанийг үүсгэн байгуулах ажилд гар бие оролцсон байна.

Удирдлагын баг

Манай компанийн үнэлшгүй хөрөнгө:
Салбарынхаа сор залуусаас бүрдсэн **Хүчтэй баг**



Чулууны **ГАНХУЯГ**
Гүйцэтгэх Захирал

Унгарын Будапешт хотын
Корвинус Эдийн Засгийн их сургууль
Санхүүч



Жаргалангийн **АЛТАНГҮНИЙ**
Төр Засаг, Олон Нийтийн Харилцаа
Эрхэлсэн Захирал

Тайваны Үндэсний
Шинжлэх Ухааны их сургууль
Бизнесийн удирдлагын мастер



Батбилэгийн **ЗОЛБОО**
Санхүү Эрхэлсэн Захирал

АНУ-ын Нью-Йорк
Мужийн их сургууль
Санхүүч



Энхсайханы **АМАРБАЯСГАЛАН**
Хөрөнгө Оруулалтын Тэргүүн Банкир

АНУ-ын Индианагийн их сургууль
Бизнесийн удирдлагын мастер



Сүхбаатарын **АНАР-ЭРДЭНЭ**
Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Захирал

БНХАУ-ын Бээжингийн их сургуулийн
Хууль зүйн сургууль
Эрх зүйч



Мөнхбатын **МӨНХ-ЭРДЭНЭ**, CPA, CPTA
Дотоод Аудитор

Мандах Их сургууль
Аудитор, Мэргэшсэн нягтлан бодогч



Цолмонгийн **БАРХАС**
Маркетинг Эрхэлсэн Захирал
Ард Холдингс Интернэшнл ХХК-ийн
Гүйцэтгэх Захирал

АНУ-ын Виржиниагийн Олон Улсын
их сургууль
Бизнесийн удирдлага



Баярсайханы **ОЮУТЦЭЦЭН**, ACCA
Эрсдэл Эрхэлсэн Захирал

Их Британийн Лондон хотын
BPP их сургууль
Санхүү, нягтлан бодох бүртгэлийн
мастер



Хангайн **ХУЛАН**
ТУЗ-ийн Нарийн Бичгийн Дарга


БНХАУ-ын Ардын их сургууль
Олон улсын харилцаа

Эдийн засгийн орчин

2020 он дэлхийн нийгэм, эдийн засагт урьд өмнө хэзээ ч үүсэж байгаагүй хүндрэл, бэрхшээл, өөрчлөлтийг авчирсан бөгөөд 1980 оноос хойш хоёр дахь удаагаа дэлхийн ДНБ-ий цэвэр өсөлт хасах үзүүлэлттэй буюу 4.4 хувийн уналттай гарлаа. Өмнөх эдийн засгийн хямралын үе буюу 2009 онд 0.1 хувийн цэвэр бууралттай байсан нь энэ удаагийнх хэр ноцтой сөрөг үр дүн үүсгэснийг илтгэнэ. Үүнд нөлөөлсөн хамгийн гол фактор нь COVID-19 цар тахал бөгөөд түүний эхний давлагааны үе буюу

оны эхэнд дэлхий даяар тогтоосон хөл хорио, хязгаарлалт нь орчин үеийн түүхэн дэхь хамгийн эрчтэй эдийн засгийн агшилтыг өдөөсөн юм. Эхний давлагааны дараа ихэнх эдийн засаг огцом сэргэх боломж үүссэн боловч Ковидын хоёр дахь давлагаа эдийн засгийг буцаан доош татав. Энэ нь хөгжингүй улс орнуудын эдийн засагт илүү хүндээр нөлөөлж тухайн орнуудын дундаж ДНБ-ий цэвэр бууралт -5.8 хувьтай байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд -3.3 хувь байна.¹

Олон Улсын Валютын Сан Дата Зураглал



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа (2020 оны 10 сар)

Ковид-19 цар тахлын үеэр Монголын эдийн засаг мөн адил огцом агшив. Засгийн газар вирусын тархалтыг хязгаарлах зорилгын хүрээнд хөл хорио тогтоох, хилээ хаах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд 2020 оны 11 сарын дунд хүртэл дотооддоо вирусын халдварыг алдаагүй байна. Энэ нь эдийн засагт маш их цочроо өгч, сүүлийн 3 жилийн хугацаанд дунджаар 6 орчим хувиар өсөж байсан Монгол Улсын ДНБ 2020 онд 5.3 хувиар агшив.¹

Засгийн Газрын зүгээс тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн эмзэг хэсгийг хамгаалах бодлого чиглэл гаргаж, ДНБ-ий 7.2 хувьтай тэнцэхүйц төсвийн хөшүүргийг хэрэгжүүлэв. Ингэснээр улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл нь 4.5 их наяд төгрөгийн алдагдалд хүрсэн бөгөөд энэ нь ДНБ-ий 12.5 хувьтай тэнцэж байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эцэст 9.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.5 их наяд буюу 13.6 хувиар буурсан байна. Харин улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 14.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.3 их наяд төгрөг буюу 19.7 хувиар өссөн байна. Монгол Улсын нийт гадаад өр жилийн хугацаанд 4.8 хувиар нэмэгдэж 32.2 тэрбум долларт хүрснээр ДНБ-ий 248 хувьтай тэнцэж байна. Харин Засгийн Газрын нийт гадаад өр төлбөр 10.8 хувиар өсөж 8.7

тэрбум доллар болсон нь ДНБ-ий 70 орчим хувьтай тэнцэж байна. Энэхүү өрийн өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь Засгийн Газраас хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих багц хөтөлбөр байсан бөгөөд түүний эдийн засгийн үржүүлбэр нь өндөр байсангүй.

Инфляцын түвшин 2019 онд 5.2 хувьтай гарч байсан бол 2020 онд 2.3 хувь болтол буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурсан байна. Монгол Улсыг 2019 оны 10 сард Олон Улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтад оруулаад байсан. Жилийн турш мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр салбар бүрт цогц арга хэмжээг авснаар 2020 оны 10 сарын 23-ны өдөр ФАТФ-ын саарал жагсаалтаас гарсан нь Монгол Улс бусадтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу 1 жилийн дотор саарал жагсаалтаас хасагдсан явдал юм.

Монгол Улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт эргэлт 12.9 тэрбум доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум доллар, импорт 5.3 тэрбум доллар боллоо. Худалдааны нийт эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үес 876.9 сая доллар буюу 6.4 хувиар, экспорт 43.3 сая доллар

¹ Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан



Мөнгө, санхүү²

Ковид-19 цар тахлын үед Монголбанк бодлогын хүүгээ тогтмол бууруулсаар нийт 500 суурь пунктээр бууруулж, 6 хувь болгосон бөгөөд хэрэглээний зээлийн өр ба орлогын харьцааны дээд хязгаарыг нэмж, банкны салбарт зорилтот урт хугацааны санхүүжилт олгожээ. Эдгээр бодлогын шууд арга хэмжээ нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж байна.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 12 сарын эцэст 24.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.3 их наяд төгрөгөөр буюу 16.0 хувиар өсөхөд валютын хадгаламж 1.2 их наяд төгрөгөөр буюу 33.2 хувиар, төгрөгийн хадгаламж 2.2 их наяд төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Санхүүгийн салбарын хувьд Монголбанк түр арга хэмжээ авч, активын ангиллын шаардлагыг зөөлрүүлж, хэрэглээний болон мортгейжийн (орон сууцны) зээлийн хугацааг сунгах, банкны салбарын

бизнесийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах боломжийг бүрдүүлэв. Эдгээр арга хэмжээ нь зээлдэгчид болон банкуудад үзүүлэх дарамт, ачааг бууруулсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 889.2 тэрбум төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 их наяд буюу 50.6 хувь нь иргэдийнх байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 445.4 тэрбум төгрөг буюу 54.1 хувиар өссөнөөр нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзэлж, өмнөх оноос 2.8 пунктээр өссөн байна. Чанаргүй зээлийн хувьд 2.0 их наяд төгрөг болсноор өмнөх оноос 184.5 тэрбум төгрөг буюу 10.1 хувиар өсөж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.7 хувийг эзэлжээ.

буюу 0.6 хувиар, импорт 833.6 сая доллар буюу 13.6 хувиар тус тус буурчээ. Гадаад худалдааны тэнцэл 2019 онд 1.5 тэрбум долларын ашигтай гарсан бол 2020 онд өмнөх оноос 790.3 сая доллароор нэмэгдэж, 2.3 тэрбум долларын ашигтай байна.

Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс гадна гадаад худалдааны дийлэнхийг бүрдүүлэгч уул уурхайн салбар эдийн засагт ихээхэн түлхэц боллоо. Дэлхийн зах зээл дээр алтны үнэ өссөнтэй холбоотой дотоодын алт олборлолт нэмэгдэж, БНХАУ-ын Монголоос худалдан авах нүүрс болон зэсийн эрэлт нэмэгдснээр уул уурхайн салбарын тээвэр, худалдааны салбарт эерэг үр нөлөө гарсан

байна. БНХАУ-тай 2020 онд 7.4 тэрбум долларын худалдаа хийсэн нь нийт бараа эргэлтийн 57.5 хувийг эзэлж байгаа бол БНХАУ руу экспортолсон бараа бүтээгдэхүүний 36.6 хувийг чулуун нүүрс, 32.4 хувийг зэсийн баяжмал бүрдүүлж байна.

2020 онд тулгарч буй бэрхшээлийг үл харгалзан, ашиглагдаагүй байгалийн баялаг болон экспортыг шингээж авах чадвартай, хурдацтай хөгжиж буй хөрш гүрнүүдийн хэрэгцээ, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл дунд хугацааны Монгол Улсын эдийн засгийн төлөв харьцангуй тогтвортой харагдаж байна.

² Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хөрөнгийн зах зээл³

2020 оны онцлох өсөлтийг дурьдвал дэлхийн хөрөнгийн зах зээлийг илтгэх MSCI World Index 14 хувиар, алтны ханш 28 хувиар, дэлхийн бондын зах зээлийг илтгэх Barclays Aggregate Bond Index 5 хувиар тус тус өсөв. Ингэснээр дэлхийн хөрөнгийн зах зээл 2 жил дараалан хоёр оронтой өсөлтийг үзүүллээ. Энэхүү өсөлтийн томоохон хэсэг болох технологийн сектор нь мөн адил 2 жил дараалан хоёр оронтой өсөлт үзүүлсэн бөгөөд 2020 онд 40 хувиар өссөн байна.

Гэсэн хэдий ч 2020 онд хөрөнгийн зах зээлийн бүх сектор өсөөгүй. Жишээлбэл, цар тахлын улмаас дэлхийн эдийн засгийн идэвхжил саарч, эрчим хүчний хэрэгцээ буурснаар газрын тосны ханш (WTI crude) 24 хувиар унасан. Мөн Ковид-19 цар тахал олон тооны бизнесийг сүйрэл, дампууралд хүргэсэн нь зарим секторын уналтын шалтгаан болов. АНУ-ын хамгийн том 500 компанийн зах зээлийн үнэлгээг илтгэгч S&P 500 индексын компаниудын хувьд эрчим хүчний салбарын уналт хамгийн их буюу 37 орчим хувийн уналтыг үзүүлэв. Мөн ахуйн, санхүүгийн, үл хөдлөхийн салбар бага зэргийн уналттай байлаа.


АНУ-ын хөрөнгийн зах зээлд голлох 3 индекс болох S&P 500, технологийн компаниудын үнэлгээг илтгэх индекс болох NASDAQ болон Dow Jones Industrial

Average (DJIA) буюу хамгийн том 30 компанийн зах зээлийн үнэлгээг илтгэх индексүүд бүгд өсөлттэй байсан. Хамгийн их өсөлтийг цар тахлын үед эрэлт, хэрэгцээ нь нэмэгдсэн технологийн шийдэл боловсруулагч компаниудын үнэлгээ өсөж, NASDAQ индекс жилийн хугацаанд 43.4 хувийн өсөлтийг үзүүлжээ.

Европын зах зээлийн хувьд цар тахалтай холбоотой хөл хорио, хязгаарлалт нь зах зээлд сөргөөр нөлөөлсөн. Лондон (FTSE 100) болон Парисын (CAC 40) хөрөнгийн зах зээлийг илтгэх индексүүд 13.1 хувь болон 6.3 хувийн тус тус уналттай байсан бол цар тахлын эхний давлагаанаас хойш тухайн орнуудын эдийн засаг сэргэхэд хүндрэлтэй байв. Харин Франкфуртын хөрөнгийн зах зээлийг илтгэх DAX 30 индекс нь жилийн 3.5 хувийн өсөлт үзүүлсэн байна.

Ази тивийн хөрөнгийн зах зээлийг илтгэх индексүүд болох Токиогийн NIKKEI болон Шанхайн SSE Composite Index нь 16 хувийн болон 12 хувийн өсөлттэй байсан бол Хонг Конгийн Hang Seng Index (HSI) нь 4 хувийн уналттай гарчээ.

Дэлхий дээрх голлох санхүүгийн төвүүдийг илтгэх индексүүдийн 2020 оны эцсийн хаалтын ханш, жилийн өөрчлөлт болон ханшийн график




2020 онд Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь мөн адил хөл хорио болон хил хязгаарлалтаас үүдсэн уналттай учирсан ч зах зээл нийтдээ жилийн 12.5 хувийн өсөлтийг үзүүлснээр 5 жил тасралтгүй үргэлжилж буй өсөлтийг хадгалж, нийт зах зээлийн үнэлгээ 3.3 их наяд төгрөгт хүрч, сүүлийн 5 жилийн хугацаанд нийт үнэлгээ 105.3 хувиар өсөв. Энэхүү өсөлтийг бүрдүүлж буй гол хүчин зүйл нь зах зээл дээр шинээр гарч ирж буй үнэт цаасууд байсан бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн компаниуд гол нөлөөг үзүүлэв.

³ Эх сурвалж: Credit Suisse, CNBC, Yahoo Finance, Монголын Хөрөнгийн Бирж

Зах зээлийн үнэлгээ

(их наяд төгрөг)



Ард Менежментын үүсгэн байгуулсан Монголын анхны хаалттай хамтын Хөрөнгө Оруулалтын Сан болох Үндэсний Хувьчлалын Сан нь 2020 оны 10 сарын 5-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэгдсэн түүхэн үйл явдал болов.

Харин Монголын хөрөнгийн зах зээлийн хамгийн том болон хамгийн их арилжаалагддаг 20 компанийн зах зээлийн үнэлгээг илтгэгч ТОП-20 индекс нь жилийн хугацаанд 336.06 нэгжээр буюу 1.7 хувиар буурч, 19,285.80 нэгж болсон байна. MSE A буюу үнэт цаасны I ангиллын индекс болон MSE B буюу үнэт цаасны II ангиллын индекс хувьд тус тус 4.3 хувь болон 4.7 хувийн уналттай хаагдав.


Түүхий эдийн зах зээл⁴

2020 он түүхий эдийн зах зээлийн хувьд ч мөн тааварлашгүй, тогтворгүй жил тохиов. Дэлхийн эдийн засгийн “термометр” гэгдэх газрын тосны фьючерс ханш оны хоёрдугаар улиралд буюу Ковидын нөлөөгөөр сөрөг болж, газрын тосны томоохон нийлүүлэгчид болох АНУ болон ОПЕК-ын улсууд нийлүүлэлтээ танаснаар ханшийг дэмжиж чадсан ч оны туршид цар тахлын өмнөх үеэс даруй 2 дахин бага ханшаар арилжигдсан юм. Монгол Улсын хувьд нийт импортын 20 орчим хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлдэг тул нефтийн ханш буурсан нь гадаад худалдааны тэнцэлд эерэгээр нөлөөллөө. Харин алтны ханш геополитикийн эрсдэл, эдийн засаг саарах эрсдэл үүсэх үед өсдөг тул цар тахлын нөлөөгөөр оны туршид чангарснаар түүхэн дээд ханш болох 2,067 долларт хүрсэн юм. Ийнхүү дэлхийн зах зээл дээр алтны ханш өсөж, хилийн хязгаарлалттай холбоотойгоор хууль бусаар алт хилээр нэвтрүүлэн гаргах тохиолдол буурснаас гадна дотоодод томоохон алтны үндсэн орд ашиглалтад орсноор Монголбанкны 2020 оны эцсийн байдлаар худалдан авсан үнэт металлын хэмжээ оны нийт дүнгээр 23.6 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.3 тонноор нэмэгдэж, гадаад валютын нөөц 900 орчим сая доллараар өслөө. Энэ нь түүхэн дэхь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Зэсийн зах зээлийн хувьд хэдийгээр 2020 оны эхэн үед цар тахлын нөлөөллөөр эрэлт буурах хүлээлт үүсэж, ханш огцом унасан боловч нийлүүлэлт талаас хомстолтой, оны сүүлийн хагас жилд дэлхийн нийт зэсийн хэрэглээний 50 хувийг бүрдүүлэгч Хятадын эдийн засаг сэргэснээр үнэ ханш нь өдөөгдөж, жилийн хувьд 26 хувийн өсөлт үзүүлээ. Монгол Улсын зэсийн экспорт 2019 онд 1.4 тонн, үнийн дүнгээр 1.8 тэрбум доллар байсан бол 2020 онд 1.36 тонн, үнийн дүнгээр 1.78 тэрбум доллар болов. Дэлхийн гангийн үйлдвэрлэлийн 50 хувийг Хятад улс хангадаг тул Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох коксжих нүүрс болон төмрийн хүдрийн ханш нь Хятадын эдийн засаг, улс төр, геополитикийн байдал, дотоодын коксжих нүүрсний нийлүүлэлт, хүчин чадал зэргээс ихээхэн хамаардаг. 2020 оны эхэн үед Хятад улс цар тахлын нөлөөгөөр хөл хорио тогтоож, улмаар эдийн засгийн өсөлт нь саарч, коксжих нүүрс болон төмрийн хүдрийн эрэлт буурснаас гадна дэлхийн гангийн эрэлт буурч, үнийн өсөлт саараад байсан бол оны сүүлийн хагаст Хятадын эдийн засаг сэргэж, дэлхийн гангийн эрэлт аажмаар өсөхийн сацуу бусад гол нийлүүлэгч улсуудын үйлдвэрлэл буурах хүлээлтээр ханш өсөв. Монгол Улсын хувьд 2019 онд 36.6 сая тонн нүүрс экспортолсон бол 2020 онд 28.7 сая тонныг

⁴ Эх сурвалж: Блүүмбэрг Терминал, Reuters

Зах зээлийн индекс



Арилжааны идэвхийн хувьд нийт 65.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээр өмнөх жилийн дүнгээс 54.4 хувиар буурав. Тайлант хугацаанд өдөрт дунджаар 263.4 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 82.5 хувийг хувьцааны арилжаа, 0.9 хувийг засгийн

газрын үнэт цаасны арилжаа, 7.8 хувийг Хөрөнгө Оруулалтын Сангийн нэгж эрхийн арилжаа, 8.9 хувийг компанийн бондын арилжаа тус тус бүрдүүлсэн байна. Хамгийн идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаас нь нийт арилжааны 90.2 хувийг эзэлсэн бөгөөд үүнд Ардын хувьцаат компаниуд бүгд багтав.

экспортолж, 21.6 хувийн бууралт үзүүлсэн бол үнийн дүнгээр 2019 онд 3 тэрбум доллар байсан нүүрсний экспорт 2020 онд 2.1 тэрбум болж, өнгөрсөн оноос 30 хувиар буурав. Төмрийн хүдрийн хувьд 2019 онд 8.5 сая тонныг 576.7 сая доллараар экспортолсон

бол 2020 онд 8.2 тонныг экспортлон 640 сая долларын орлоготой байсан нь хэмжээ болон үнийн дүнгийн хувьд 3.5 хувийн бууралт, 11 хувийн өсөлтийг тус тус үзүүллээ.

Монгол Улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий түүхий эдийн 2020 оны эцсийн хаалтын ханш, жилийн өөрчлөлт болон ханшийн график:



Валютын зах зээл⁵

2020 онд Монголбанкнаас гадаад валютын албан нөөцийн хэмжээг 4.27 хувиар нэмэгдүүлж 4.5 тэрбум долларт хүргэсэн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн америк доллартай харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 сард 2,849.55 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.5

хувиар суларчээ. Мөн төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 12 сард 435.64 төгрөг болж, жилийн хугацаанд 12.1 хувиар суларсан байна. Харин төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш оны эцэст 38.42 төгрөг болж, тайлант хугацаанд 11.4 хувиар чангарсан байна.


Үзүүлэлт	2018	2019	2020
Америк доллар	2,637.35	2,727.34	2,849.55
Жилийн өөрчлөлт	8.4%	3.4%	4.5%
Евро	3,002.43	3,030.51	3,466.18
Жилийн өөрчлөлт	4.3%	0.9%	14.4%
Юань	383.03	388.75	435.64
Жилийн өөрчлөлт	3.8%	1.5%	12.1%
Рубль	39.15	43.38	38.42
Жилийн өөрчлөлт	-5.7%	10.8%	-11.4%

⁵ Эх сурвалж: Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо

Криптовалютын зах зээл⁶

2020 он нь криптовалютын зах зээлийн хувьд урьд өмнө учирч байгаагүй, таамаглашгүй жил байсан. Ковид-19 цар тахлаас улбаалсан санхүү, эдийн засгийн уналт крипто зах зээлд их хэмжээний савалгаа үүсгэж байсан ч дэлхий даяарх цахим шилжилттэй холбоотойгоор цар тахлыг үл тоон нийт крипто зах зээлийн үнэлгээ 190.9 тэрбум доллараас 760.7 тэрбум долларт хүрч, 4 дахин өсөв.

Цар тахлаас үүдсэн хөрвөх чадварын хямралтай уялдаж 3 сард Биткойн 50 орчим хувиар унасан ч эрчтэй сэргэж, экспоненциал өсөлтийг үзүүлснээр жилийн хугацаанд 300 хувиар өсөв. 5 сард Биткойн нь үүссэн цагаасаа хойш гурав дахь удаагаа хуваалт хийсэн бөгөөд олборлолтын урамшуулалд өгдөг Биткойны хэмжээ хоёр дахин буурсан юм. Өөрөөр хэлбэл Биткойны инфляци хоёр дахин буурсан байна.



Оны хоёрдугаар хагаст Биткойн нь өдөр бүр түүхэн дээд ханшаа эвдэж байсан бөгөөд энэ бүхэн 8 сард Microstrategy 250 сая долларын бэлэн мөнгөний нөөцөө Bitcoin болгож байгаагаа зарласнаас эхэлсэн юм.

Microstrategy болон Square-ээс гадна бусад санхүүгийн байгууллагууд криптовалютын зах зээлийг дэмжихээ илэрхийлж эхэлсэн юм. Заримаас нь дурдвал, өмнө нь криптог үл ойшоож байсан Goldman Sachs нь виртуал хөрөнгийн арилжааны албатай болсноо зарласан. Мөн дэлхийн хамгийн том хөрөнгө оруулагчдын нэг болох Fidelity нь чинээлэг хөрөнгө оруулагчдадаа зориулан Биткойны хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулсан бөгөөд харилцагч нартаа хөрөнгө оруулалтын багцынхаа 5 хувийг Биткойн болгохыг зөвлөв. Сингапурын DBS банк мөн адил өөрсдийн дижитал хөрөнгийн арилжааны бирж байгуулахаа мэдэгдсэн бол Citibank 2021 оны эцэст Биткойныг 300 мянган доллар давах боломжтой гэж таамагласан нь дэлхийг гайхшруулсан.

Хөрөнгө оруулалт хийхээс гадна томоохон санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаандаа криптовалют нэвтрүүлж, харилцагчдадаа санал болгож эхэлсэн. Paypal 10 сард 300 сая хэрэглэгчдэдээ шууд криптовалют худалдаж авах боломжийг олгохоо зарласан. Худалдан авалтыг хөнгөвчлөх зорилгоор арилжааны бирж болох Paxos-той хамтран ажилласнаар PayPal-ын хэрэглэгчид хөрөнгөө крипто, ялангуяа Bitcoin руу асар их хэмжээгээр шилжүүлж эхлэв.

2020 онд Decentralized Finance (DeFi) буюу төвлөрсөн бус, эзэнгүй, олон нийтэд нээлттэй санхүүгийн үйлчилгээ нь зах зээл дээр шинэ

боломжийг нээж өгсөн. DeFi-ийн хамгийн хувьсгалт санаа бол yield farming буюу хүү тооцож авах санаа байв. Шинэ протокол, yield farming буюу хүү тооцож авах шинэ төсөл, санаачилгууд долоо хоног бүр зарлагдаж байсантай холбоотой DeFi зах зээлд орсон криптовалютын нийт үнэлгээ 700 сая доллараас 15 тэрбум болж 23 дахин өссөн байна. DeFi-ийн огцом өсөлт нь дийлэнх криптовалютын суурь болсон Ethereum-ийг өргөтгөх шаардлагатай байгааг харуулав. Учир нь Этериум дээр гүйлгээ хийхэд маш өндөр зардалтай болж эхэлсэн юм. Иймээс Этериумын нийгэмлэг, хөгжүүлэгчид системийн шинэчлэл хийж 2.0 хувилбарыг 12 сард нэвтрүүллээ.

2020 оны хамгийн тод хөгжил, дэвшлийн нэг бол Stablecoin буюу фиат мөнгийг шууд илэрхийлэх цахим мөнгөний нийлүүлэлт эрчимтэй нэмэгдсэн явдал юм. Америк долларыг илэрхийлэх Тетер (USDT) 20 тэрбум гаруй долларын нийлүүлэлтийг давснаар 20 тэрбум фиат доллар дижитал хэлбэрт шилжиж Тетер болсон.

Жилийн өмнө зах зээлд нийлүүлэх цаг хугацаа нь тодорхойгүй байсан Хятадын дижитал юаний хөгжил 2020 онд хурдацтай ахиж, улс орон даяар туршилтын хөтөлбөрүүдийг эхлүүлэв. Төв банкны цахим мөнгө нь илүү уян хатан, үр ашигтай төлбөрийн системийг бий болгож, уламжлалт банкны бүтцийг түйвээх төлөвтэй байна.

⁶ Эх сурвалж: coinmarketcap.com, crypto.com

Гүйцэтгэлийн тайлан

Маркетинг

2020 онд дэлхий дахинд Ковид-19 цар тахал дэгдэж, бидний амьдралын хэв маяг, нийгмийн харилцаанд өөрчлөлт орсон амаргүй цаг үе байсан хэдий ч Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниуд цахим шилжилтийн бодлогыг эртнээс эхлүүлсэн тул шинэ нөхцөл байдалтай хамгийн богино хугацаанд дасан зохицсоноор зорилго зорилтуудаа амжилттай биелүүлж чадсан жил байлаа. Тус онд хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахимаар зохион байгуулж, Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох үйл ажиллагааны хүрээнд Европ тив, Монгол орон даяар бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэж, сургалт танилцуулга хийлээ. Монгол ТВ-тэй хамтран зохион байгуулсан Аппрентис Монгол Шоу нэвтрүүлэг маань олны хүртээл болсон бол бид АрдКойны хэрэглээнд түлхүү анхаарч ажилласнаас гадна цахим хөрөнгийн бирж болох Digital Assets Exchange буюу DAX-ын үйл ажиллагааг эхлүүлж, Ард Академиар дамжуулан олон нийтийн санхүүгийн боловсролд үнэ цэн бүхий хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр ирлээ.

Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай хүргэх нь бидний зорилготой нийцэхээс гадна сошиал медиаг ашиглан цаг алдалгүй мэдээ, мэдээлэл дамжуулахад анхаарав.

Жил бүр зохион байгуулдаг хувьцаа эзэмшигчдийн хурал, жилийн тайлан, улирлын тайлангаа эрхэм хувьцаа эзэмшигч, харилцагчдадаа саадгүй хүргэж ажиллав. Мөн Ard Talk Show-аар 7 хоног бүр санхүүгийн зах зээлийн тойм мэдээг хүргэж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ Ардын влогоор сурталчлан, урамшуулалтай холбоотой болон цаг үеийн мэдээллээ Facebook Live хэлбэрээр зохион байгуулах зэргээр сошиал медиад зориулсан сонирхолтой бүтээлүүдийг амжилттай гаргаж, олон зуун мянган хэрэглэгчдэд хүргэлээ. Цаашид дижитал маркетингийн үйл ажиллагааг улам нарийн мэргэжлийн, ахисан түвшний хэрэгсэл, нөөц, судалгаа ашиглан явуулах болно.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Европ – Хилийн чанадад суугаа Монголчууд гадаад дахь гар утасны дугаараараа Ард Аппдаа бүртгүүлэх боломжтой болсон бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх Захирал Ч.Ганхуяг Европын Будапешт, Прага, Вена, Мюнхен, Штутгарт, Берлин хотуудаар, мөн Франц, Швейцар улсуудаар Ардын бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга сургалтаа 2020 оны 6 сараас 8 сар хүртэл хийж 300 гаруй Монголчуудыг идэвхтэй хамруулж оролцууллаа.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөө орон нутагт аяны хүрээнд Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хөрөнгө оруулалттай компаниудын төлөөлөл зуны 3 сарын туршид Өвөрхангай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай, Хархорин, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан аймаг, Тосонцэнгэл суманд санхүүгийн боловсрол олгох сургалт, бүтээгдэхүүн үйлчилгээ танилцуулах арга хэмжээг амжилттай зохион байгуулав. Уг үйл ажиллагаанд алслагдмал баг сумдаас зорин ирж сургалтад сууж буй иргэд цөөнгүй байсан нь уг сургалт үр өгөөжтэй байсныг илтгэж байлаа.

Тус арга хэмжээнд Ард Лайф ХХК-ийн Гүйцэтгэх Захирал Б.Гантулга “Тэтгэврийн шинэчлэл, Хувийн тэтгэврийн хуримтлалаа хэрхэн бүрдүүлэх вэ”, Ард Кредит ХК-ийн Гүйцэтгэх Захирал Г.Тэлмэн “Санхүүгийн харилцаанд хариуцлагатай оролцох нь”, Ард Актив ХЗХ-ны Гүйцэтгэх Захирал Г.Билгүүн “Хувийн санхүүгээ хэрхэн удирдах вэ”, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү Хариуцсан Захирал Б.Золбоо “Хувийн санхүүгээ удирдах нь”, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хөрөнгө Оруулалт Захирал Э.Амарбаясгалан “Хувьцаа, Бонд, Тэтгэвэр” сэдвээр тус тус сургалт зохион байгуулж, нийт 2,000 гаруй хүнийг хамруулжээ.

Санхүү бизнесийн салбарт салхи оруулж Монгол

ТВ-тэй хамтран хийсэн Аппрентис Монгол Шоу нэвтрүүлгийн анхны дугаар 12 сард цацагдсан бөгөөд үзэгч түмний сайшаал магтаал хүртэхийн хажуугаар санхүү, бизнесийн мэдлэг боловсролыг түгээхэд томоохон ач холбогдол бүхий бүтээл болсныг нийт харилцагч, үзэгчдийн зүгээс илэрхийлж байна. Тус нэвтрүүлэгт бид Ард Лайфын хувийн тэтгэврийн хуримтлал, манай супер апп болох Ард Апп, түүнийг дагалдах АрдКойн болон Ард Даатгалын эрүүл мэндийн Ард Мэнд бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд таниулах зорилгоор хамтран ажиллалаа. Өнгөрсөн хугацаанд Монголын анхны блокчэйнд суурилсан харилцагчийн урамшууллын оноо болох АрдКойныг зах зээлд нэвтрүүлж, хэрэглэгчдийг татах, идэвхжүүлэх зорилгоор тарааж байсан бол 2020 онд хэрэглээнд илүү анхаарч АрдКойноо зарцуулах, ашиглах зөвлөмжийг маркетингийн төлөвлөгөөнд тусгаж ажилласан билээ. Тухайлбал, АрдШоп, Ард Лайф компаниуд АрдКойноор хөнгөлөлт эдлэх боломжуудыг, харин DAX нь блокчэйн технологид суурилсан крипто, секюрити токен арилжаалах гарцыг нээж өгөв. Мөн АрдКойн Монголын хамгийн анхны олон улсын крипто бирж болох BitMonex-д бүртгэгдэж тус оны 5 сарын 5-наас арилжаалагдаж эхэлснээр АрдКойныг авах зарах сонголтууд нэмэгдсэн юм. Ард Академи – Санхүүгийн мэдлэгийг тогтмол



түгээх, харилцагч хэрэглэгчдээ мэдээллээр хангах үүднээс 7 хоног бүр хувийн санхүү, хөрөнгө оруулалт болон санхүүтэй холбогддог бусад салбарын мэргэжилтнээс ярилцлага нийтлэл бэлтгэн хүргэхээс гадна цахим сургалт зохион байгуулдгаараа харилцагчдад хэдийн танил болсон билээ. 2020 оны сүүлийн байдлаар цахимаар болон танхимаар 38 удаа сургалт хийж, вэбсайтаа 136 нийтлэл оруулсан бол уншигчийн зүгээс 125,862 удаа уншихдаа, 2,387 цаг зарцуулжээ. Мөн санхүүгийн мэдлэгийг орон даяар түгээх үүднээс мөнгө санхүү, хөрөнгө оруулалтын ойлголтыг 5 минутад 3 өөр мэдлэгийн түвшинтэй хүмүүст тайлбарласан сонирхолтой 10 цуврал дугаар хийж, сошиал сувгуудаар болон Монгол ТВ-ээр түгээсэн байна.

2020 оны томоохон амжилтуудын нэг болох Монголын анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан үйл ажиллагаагаа эхлүүлэн 5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх ажлаа 10 сард амжилттай гүйцэтгэж (Үндэсний Хувьчлалын Сан нь тус бүр 100 төгрөгийн

нэрлэсэн үнэтэй 50 сая ширхэг нэгж эрх гаргаж, үүнийхээ 95 хувийг буюу 47 сая 500 мянган ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгосон юм), захиалгаа 1 тэрбум орчим төгрөгөөр буюу 16.5 хувиар давуулан биелүүлж, нийт 3,272 харилцагч захиалга өгснөөс 2,245 харилцагчийн захиалга биелж, анхдагч арилжааны захиалга хаагдсан билээ. Хөрөнгө Оруулалтын Сангийн талаар олон нийтийг мэдээллээр хангаж, маркетинг идэвхжүүлэлтийн арга хэмжээг амжилттай хийсэн нь татан төвлөрүүлэх хөрөнгөө давуулан биелүүлэхэд ихээхэн түлхэц болж өгсөн юм.

Нийт хувьцаа эзэмшигчид, хамтрагч байгууллагууд, харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж, маркетингийн үйл ажиллагаагаа цахим орчинд саадгүй явуулснаар, Ард Апп хэрэглэгчдийн тоо 2020 оны эцэст 637,000 болж, хэрэглэгчдийн гарт 4.7 тэрбум АрдКойн хүрсэн үзүүлэлтэй байна.

Хүний Нөөц

Ард Холдингс үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн хүний нөөцийн хувьд цомхон, ажиллагсад нь хамгийн боломжит байдлаар давхар үүрэг гүйцэтгэж ирсэн түүхтэй.

2020 оны хувьд Холдингсын хэмжээнд 9 үндсэн ажилтантай ажилласан бөгөөд туслах бүхий л ажлыг гуравдагч компаниар гэрээгээр гүйцэтгүүлсэн болно. Гүйцэтгэх Захирал, Санхүү Эрхэлсэн Захирал, Үйл Ажиллагаа Эрхэлсэн Захирал, Маркетингийн Захирал, Дотоод Аудитор, Хөрөнгө Оруулалт Эрхэлсэн Захирал, Дижитал Технологийн Захирал, Ерөнхий Нягтлан Бодогч, TV3-ийн Нарийн Бичгийн Дарга Нэгдлийн хэмжээнд ажиллаж, оны дундаас Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Захирал, Эрсдэл Эрхэлсэн Захирал нарыг томилов. Хянан Нийцүүлэлт Эрхэлсэн Захирлаар Сүхбаатарын Анар-Эрдэнэ, Эрсдэл Эрхэлсэн Захирлын албан тушаалд Баярсайханы Оюутцэцэнг тус тус томилов.

С.Анар-Эрдэнэ нь БНХАУ-ын Бээжингийн их сургуулийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн ба Бээжинд байх хугацаандаа олон улсын Дэнтонс хуулийн фирмийн Бээжин дэх төв оффис, АНУ-ын Шерман Стерлинг хуулийн фирмийн Бээжин дэхь салбарт тус тус дадлагажин ажиллаж байсан бөгөөд 2016-2020 оны хооронд Дэнтонс хуулийн фирмийн Улаанбаатар хот дахь салбарт ажилласан.

Б.Оюутцэцэн нь Их Британийн Лондон хотод санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр магистрын зэргээ хамгаалж, 2020 онд АССА буюу Олон Улсын Мэргэшсэн Нягтлан бодогч зэргийг хүртсэн ба Монинжбар ХК, БДО Аудит ХХК, Голомт банкинд ажилласан туршлагатай.

Охин компаниудын удирдлагад өөрчлөлт орж Ард Кредитын Гүйцэтгэх Захирлаар Гэрэлтийн Тэлмэн, MEC Partners буюу АрдШопын Гүйцэтгэх Захирлаар Ард Холдингсын Маркетинг Эрхэлсэн Захирлаар ажиллаж байсан Баяраагийн Ариунаа томилогдов. Г.Тэлмэн нь БНСУ-ын LG-ийн гадаад, дотоодын худалдаа, хөрөнгө оруулалтын компанид менежментийн болон гүйцэтгэх удирдлагын түвшинд 10 гаруй жил ажилласан туршлагатай. 2016 онд Монгол Шуудан ХК-ийн хувьчлалын дараа компанийн Стратеги Төлөвлөлт, Бизнес Хөгжил Хариуцсан Дэд Захирлаар томилогдож 3 жилийн дотор компанийн ашигт үйл ажиллагааг 15 дахин нэмэгдүүлж, логистикын үйл ажиллагааг бүс нутгийн хэмжээнд тэлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Б.Ариунаа нь АНУ-ын UCLA их сургууль, Anderson Менежментийн сургуулийг Бизнесийн удирдлагын мастер зэрэгтэй төгссөн. Blue Sky Hotel & Tower, АНУ дахь Etugen Cashmere онлайн брэнд төслүүдийг удирдан ажилласнаас гадна Ард Санхүүгийн Нэгдлийн Маркетинг Эрхэлсэн Захирлын албыг хашсан туршлагатай.

Америкийн алдарт MGM продакшны бүтээл болох The Apprentice бизнесийн реалити шоуны онцгой эрхийг Монгол Телевиз анх удаагаа авч Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран зохион байгуулав. Бизнесийн ертөнцийн ширүүн тулаанд хөл алдалгүй бат зогсох шилдэг менежерийг эзэмшсэн ур ухаан, авхаалж самбаа, харилцаа манлайллын ур чадвараар нь олон түмнийхээ нүдэн дээр ил тодоор сорин тодруулахаар Ч.Ганхуяг захирал зориг шулуудаж, жилийн 200 сая төгрөгийн цалин, Гүйцэтгэх захирлын албан тушаал, хангамжийг амлан 1,000 гаруй залуусаас эн тэнцүү өрсөлдөхүйц 14 оролцогсдыг сонгон шоугаа эхлүүлсэн. Тэдний дундаас шоуны ялагчаар Цолмонгийн Бархас шалгарч, Ард Холдингс Интернэшнл ХХК-ийн Гүйцэтгэх Захирлаар томилогдлоо.

Ц.Бархас нь байгууллагын санхүү, маркетинг, менежментийн чиглэлээр 8 жил ажилласан туршлагатай бөгөөд салбар хариуцсан менежер, маркетингийн албаны дарга болон ерөнхий менежерийн албан тушаал хашиж байсан туршлагатай. Тэрээр бизнес, эдийн засгийн чиглэлээр СЭЗИС-д бакалаврын зэрэг, мөн АНУ-ын Виржиниагийн Олон Улсын Их Сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр мастер цол хамгаалжээ. Ардын охин компаниудын нэг болох Ард Лайф ХХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлаар Аппрентис Монгол Шоуны оролцогсдын нэг Отгонбаярын Амарболд томилогдлоо.

О.Амарболд нь Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, БНСУ-ын Корэйн Эйрын нисэхийн сургууль, БНХАУ-ын Олон Улсын Бизнес, Эдийн Засгийн Их Сургуулийг төгссөн гадаад харилцааны ажилтан, агаарын хөлгийн үйлчлэгч, компанийн засаглалын удирдлагын мэргэжилтэйгээс гадна Хятад, Англи хэл эзэмшжээ. Амарболд нь МРА Группын худалдааны менежер, Оюу Толгой ХХК-ийн хангамжийн менежер, БНХАУ дахь төлөөлөгчийн газрын дарга, МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн үйлчлэгч, БНХАУ-ын уул уурхай, эрчим хүчний Шинхуа Группын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн Бичгийн Дарга, Үйл Ажиллагаа Хариуцсан Захирал ба Тэргүүн Дэд Захирлаар ажилласан арвин туршлагатай юм.

Бид 2020 оны гүйцэтгэл дээр тулгуурлан Ард Даатгал, Ард Кредит, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа, Ард Лайф хувийн тэтгэврийн данс, АрдКойноор тэнцүү хуваан нийт ажилтнууддаа онцгой урамшуулал олгохыг шийдвэрлэсэн юм. Харин ТУЗ-ийн гишүүдэд 234. сая төгрөгтэй тэнцэх, удирдлага болон ажиллагсдад нийт 525 сая төгрөгтэй тэнцэх урамшуулал олгосныг дуулгахад таатай байна. Бид багаа хамгийн чадварлаг, авьяаслаг, хамгийн гол нь сэтгэлтэй залуусаар бүрдүүлэхийг эрмэлзэж ирсэн бөгөөд тэд маань санхүүгийн асуудлаа бүрэн шийдсэн байх ёстой гэж үздэг философийг мөрдөж ирсэн билээ.

Технологи

Банкны үндсэн систем болох Поларис програмыг Ард Кредит, Ард Лайф, Ард Секюритиз, Ард Актив, Ард Бит компаниудад бүрэн нэвтрүүлсэн бөгөөд энэ онд шинээр үйл ажиллагаа эхлүүлж буй Ард Лизинг компанид нэвтрүүлэх төсөл мөн эхэллээ. Энэхүү ажил амжилттай хийгдсэнээр Ард Санхүүгийн Нэгдлийн хамаарал бүхий компаниуд нэгдсэн системтэй болж, банк болох суурь тавигдаж байгаа юм.

Ард Апп All-in-One платформ нь харилцагчдадаа илүү ойртож, Үндэсний ХҮР системтэй холбогдсоноор шинэ харилцагч бүртгүүлэхэд илүү хялбар болсноос гадна олон улсаас гадаад утасны дугаараар харилцагчаар бүртгүүлэх боломжийг бүрдүүллээ. Мөн Монголбанкны Автомат Клиринг Хаус (ACH+) төлбөрийн системд нэгдсэнээр банк хоорондын гүйлгээнд шууд оролцох боломж нээгдэв.

Ард Даатгалын харилцагчид эрүүл мэнд, гадаадад зорчигч, тээврийн хэрэгслийн даатгалд Аппаасаа хамрагддаг болсон нь үйлчилгээний илүү таатай нөхцлийг бүрдүүлж өгсөн юм. Мөн Galaxy CRM буюу харилцагчийн нэгдсэн системийг Ард Даатгал компанид нэвтрүүлж, дотоод үйл ажиллагааг автоматжууллаа.

АрдШоп (www.ardshop.mn) вэбсайтын шинэчлэл, сайжруулалт үргэлжлэн хийгдэж хэрэглээг хялбаршуулах хэд хэдэн томоохон өөрчлөлтүүдийг амжилттай нэвтрүүлээд байна. Ард Апп хэрэглэгчдийг хүссэн газраасаа хүргэлтийн үйлчилгээ авах боломжийг нээж хүргэлтийн цогц үйлчилгээ болох My Delivery-г Аппынхаа үйлчилгээ цэсэд нэмсэн юм. Мөн манай компанийн үйлчилгээг зөвхөн Ард Апп буюу утаснаас биш бүх төрлийн төхөөрөмжөөс авах боломжийг олгох үүднээс бид албан байгууллага, хувь хүмүүст зориулан интернет банкны төслийг эхлүүлэв.

Монгол Шуудан ХК-тай хамтран Дэлхийн 100 гаруй улсаас олон улсын ЕвроЖайро (Eurogiro) компанийн сүлжээгээр мөнгөн гуйвуулга хийдэг боллоо. Цаашид Ард Апп дээрээс мөнгөө гуйвуулах, хүлээн авах боломжтой болгохоор ажиллаж байна. Этериум блокчэйныг банкны системтэй холбох ажил амжилттай хийгдэж, бид өөрсдийн Цахим Хөрөнгийн Бирж (Dax.mn) -тэй болох боломж бүрдсэн билээ. Трэйд.мн компанитай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээ дуусгавар болж, DAX төслийг эхлүүлэн шинэ бүтээгдэхүүнээ зах зээлд амжилттай нэвтрүүлж чадлаа. Иргэд, харилцагчдадаа виртуал хөрөнгө арилжаалах боломжийг нээж Монголд анх удаа Digital Assests Exchange буюу Виртуал Хөрөнгийн Биржийг нэвтрүүлсэн нь богино хугацаанд маш олон хэрэглэгчдэд хүрээд байна.

Ковид-19 цар тахлаас сэргийлэн Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Кредит, Ард Даатгал компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлаа анх удаа цахим хэлбэрээр хийсэн билээ.

Харилцагч бүрийн санал гомдлыг цаг алдалгүй шийдэж өгөх зорилтын хүрээнд харилцагчийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг автоматжуулан Call Pro программыг нэвтрүүлж, банкны суурь систем болох Поларистай холбосон. Арджуулах хөтөлбөрийг эхлүүлж, Ард Санхүүгийн Нэгдлийн ажиллагсдадаа зориулан онлайн сургалтын системийг нэвтрүүлэн дотоод сургалтыг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн юм.

Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж зэрэг зохицуулагч байгууллагаас ирсэн: “Dax.mn дээр арилжаалагдаж буй секюрити токен нь одоогоор зохицуулагдаагүй байгаа бөгөөд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цааснаас ялгаатай” болохыг онцлоод, ялгаатай тикер агшиглах санал ирүүлсний дагуу Dax.mn Виртуал Хөрөнгийн Бирж дээр арилжаалгддаг AARD токены нэршлийг ARDT тикертэй болгон өөрчлөв.

Мөн Монголбанкнаас: АрдКойн нь цахим мөнгөний зөвшөөрлийн дагуу зохицуулагдахгүй тул холбоотой цэсийг Ард Аппаас хасах эсвэл салган тусгаарлахыг санал болгосон ба Апп хэрэглэгчийн бүртгэл, гүйлгээний хязгаарлалттай холбоотой тохиргоо хийхийг шаардсаны дагуу Ард Кредит болон бусад хамааралтай талууд шаардлагатай бүх арга хэмжээг түргэн шуурхай авч, системийн шинэчлэлийг зохицуулагч байгууллагын заасан хугацаанд хийж гүйцэтгээд байна.

Мэдээлэл технологийн аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж системийн аюулгүй байдал болон дэд бүтцийг сайжруулах ажлыг тогтмол хийж заншив. Мөн хөндлөнгийн мэдээлэл технологийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч цаашид хэрэгжүүлэх дижитал стратегиа зураглан гаргалаа. Ард Санхүүгийн Нэгдэл нь Мэдээлэл, технологийн захирал шинээр ажилд авах шаардлагатай байгаа бөгөөд гүйцэтгэх гол үүрэг нь гуравдагч байгууллага буюу Most Money дээрх системийн ачааллын асуудлыг яаралтай шийдэж, шинэ систем нэвтрүүлэн ажиллах юм.

Хөрөнгө Оруулалт

Ард Холдингс нь стратегийн болон тактикийн хөрөнгө оруулалтууд хийдэг.

Стратегийн хөрөнгө оруулалтын багцад нэг цэгээс санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх бидний стратегийн салшгүй хэсэг болдог компаниуд ордог ба бид өсөлт хөгжилд нь санхүү болон менежментээр тасралтгүй хөрөнгө оруулж ирсэн билээ.

Ард Санхүүгийн Нэгдэл банктай болох ёстой, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ хөтлөгдөн банкинд хөрөнгө оруулах хэлцлүүдийг Ард Холдингс Интернэшнл эхлүүлж бэлтгэл ажлаа хангалаа.

Харин тактикийн хөрөнгө оруулалтын багцад санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтууд маань багтдаг.

Бид хувьцаагаа хямд байвал худалдаж авах бодлогыг баримталдаг.

2020 оны хувьд бид бизнесээ хамгаалах, хадгалах бодлого хэрэгжүүлсэн. Бэлэн мөнгөө хэмнэх, хуримтлуулах, өрөө нэмэхгүй байх, санхүүгийн зардлаа танах ажлуудыг хийсэн.

Харин Ард Активын хувьд маш эрсдэл багатай бизнес тул цар тахлын үед ч гэсэн өсгөх бодлого барьж, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангаж ажиллалаа. АрдШопын хувьд аврах ажиллагаа явагдаж, эзэмшигчдийн дундах конфликтыг шийдэж, нэмэлт хөрөнгө оруулалт хийж , хувиа нэмэгдүүлсэн. Менежментийг нь бүрэн авсан. Нээлттэй компаниудын хувьд оны ихэнх хэсэг оролцоогүй, оролцох боломж ч байгаагүй. Оны сүүлээр Ард Кредит дээр хувьцаагаа 2 том хувьцаа эзэмшигчээс буцаан авах ажиллагааг явуулсан. Ард Санхүүгийн Нэгдэл дээр 1 том хувьцаа эзэмшигчээс хувьцааг нь худалдаж авах өмнө нь байгуулсан гэрээний дагуу төлбөрүүдийг хийж гүйцэтгэв. Монгол Шуудангийн 3 хувьтай тэнцэх хувьцааг худалдан авах гэрээний дагуу бүх төлбөрийг хийж гүйцэтгэв.



DAX - Виртуал Хөрөнгийн Бирж

2020 онд Ард trade.mn-тэй хөрөнгө оруулалтын гэрээгээ цуцалж өөрийн Виртуал Хөрөнгийн Бирж болох DAX (Digital Assets Exchange)-ийг бүтээн 2020 оны 12 сараас үйл ажиллагааг нь эхлүүллээ. Энэхүү бирж нь УИХ ойрын хугацаанд батлах хүлээлттэй байгаа Виртуал хөрөнгийн хуулиар зохицуулагдах, биржээс гадуур арилжаа хийх зориулалтай блокчэйн дээр суурилсан ажилжааны платформ юм. Энэ биржээр одоогоор АрдКойн, Биткойн болон Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны токен зэрэг бүтээгдэхүүнүүд 24/7 арилжаалагдаж байна. DAX буюу Ард Экс компанийн 60 хувийг Ард Санхүүгийн Нэгдэл эзэмшдэг бөгөөд 2020 оны эцсээр өдрийн арилжааны дүн 10-20 тэрбум төгрөг байлаа. DAX арилжааны дүнгээс шимтгэлийн орлого зогсолтгүй үйлдвэрлэж байна.



Крипто Үндэстэн Сан

Сүүлийн жилүүдэд хувиараа Биткойн болон криптовалютад хөрөнгө оруулсан хүмүүс ихээр алдагдал хүлээсэн бол Ард Санхүүгийн Нэгдлийн удирдсан Крипто Үндэстэн Сан (KYC) 2020 оны 12 сард амжилттай хаагдаж хөрөнгө оруулагчдадаа 110% хувийн ашиг хуваариллаа. Бид өнгөрсөн 3 жилийн хугацаанд нийт 24.8 биткойныг хувь тэнцүүлж тараасан билээ. Энэ нь 2020 оны 12 сарын 26-ны ханшаар 1.7 тэрбум төгрөг байв. Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар KYC-г цаашид Нээлттэй компани байдлаар үйл ажиллагааг нь үргэлжлүүлэхээр болов. Сангаа үргэлжлүүлэх сонирхолтой хөрөнгө оруулагчдад зориулж бид Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Булган Ундрага ХК (BUN)-ийг худалдаж авсан бөгөөд сангийн хөрөнгийг энэ компанийн хувьцаанд хөрвүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.



Үндэсний Хувьчлалын Сан

Үндэсний Хувьчлалын Сан нь 2019 онд байгуулагдсан Монгол Улсын анхны хаалттай хамтын Хөрөнгө Оруулалтын Сан бөгөөд 2020 онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс 4.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлж нийт хөрөнгө нь 5 тэрбум боллоо. Үндсэн андеррайтераар Ард Секюритиз ҮЦК ажилласан бөгөөд энэхүү хувьчлалд Монгол лсын томоохон компаниуд болох М-Си-Эс Групп, Шунхлай Групп, Тесо Групп, даатгалын компаниуд, банкууд болон 2,239 иргэд оролцлоо. Сан нь Монгол Улс болон дэлхий даяар арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, түүнээс бий болох ашгийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилахаар зорьж байна. Сан нь 2020 оны 12 сарын сүүлээр 4.42 хувийн буюу жилээр тооцвол 25.6 хувийн өгөөжтэй ажиллалаа.



АрдШоп

АрдШопыг эзэмшдэг Эм И Си Партнерс ХХК нь технологио хөгжүүлэх, компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд өөрийн хувьцаа эзэмшигчдэдээ нэмэлт хувьцаа санал болгож, хөрөнгө оруулалт татсан ба тус компанид Ард Холдингсын эзэмшдэг хувь 40% байсан нь өсөж 61.24% болов.

АрдШоп онлайн дэлгүүрийн мобайл хувилбарын хөгжүүлэлтийн ажил 2021 оны 1 дүгээр сард амжилттай дууслаа. Энэхүү шинэ хувилбарын интерфэйс ашиглахад хялбар, илүү хурдан болсон бөгөөд хэрэглэгчдийн талархлыг хүлээгээд байна. Цар тахлын нөлөөгөөр хэрэглэгчид онлайн худалдааг илүү ихээр ашиглах болсон бөгөөд хөл хорионы дэглэм нь цахим худалдааны салбарыг өсгөх маш том хүчин зүйл боллоо. 12 дугаар сард АрдШоп онлайн дэлгүүрийн захиалгын тоо 2019 оны мөн үетэй харьцуулахад 384 хувиар өссөн үзүүлэлттэй байлаа.

Үл Хөдлөх Хөрөнгө

Шарга Морьтод байршилтай Санкт Морьт хотхоны Ганбатын хаусыг Ард Кредит нэг тэрбум төгрөгөөр худалдаж авсан бөгөөд IET компанийн хувьцаа, Ард Лайф компанид бүртгэлтэй Хийморь хотхонд байршилтай хаус, газар зэргийг компани хоорондын авлага барагдуулж төлбөрт нь өглөө.

Монголын Хөрөнгийн Биржийн Арилжаа

Ард Санхүүгийн Нэгдлийн компаниуд хувьцааныхаа үнийг дэмжих бодлого хэрэгжүүлдэг бөгөөд зах зээлийн үнэ бодит үнэ цэнээс хямд байгаа тохиолдолд хувьцаагаа нээлттэй захаас худалдаж авдаг.

2020 онд Ардын компаниудын хувьд нээлттэй зах зээл дээр хийсэн арилжааны мэдээ:

- Ард Даатгалын 0.2 хувийг 43 саяар
- Ард Кредитын 4.2 хувийг 887 саяаар
- Ард Санхүүгийн Нэгдлийн 3.3 хувийг 1.55 тэрбумаар
- Монгол Шуудангийн 4.9 хувийг 3 тэрбумаар тус тус худалдан авч нийтдээ 5.5 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ.

Санхүүгийн Гүйцэтгэл

Цар тахлын үед Ард Санхүүгийн Нэгдэл нь группын хэмжээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, боломжит өсөлтийг бүрдүүлэх зорилгоор санхүүгийн багц арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

1. Бэлэн мөнгөний урсгалыг тасалдуулахгүй байх зорилгоор байгууллагын бүх түвшинд бэлэн мөнгө хадгалах, нөөцлөх арга хэмжээний хүрээнд хамгийн түрүүнд бизнесийн оршин тогтноход шаардлагагүй бүх зардлыг танаж, бууруулав. Мөн хүчинтэй байгаа бүх гэрээний төлбөрийг хойшлуулж, төлбөрийн хуваарийг дахин хэлэлцэж гарах мөнгөн урсгалыг тарааж, аль болох хойшлуулав. Ингэснээр Нэгдлийн хэмжээнд бэлэн мөнгөний нөөц 2.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 5 тэрбум төгрөг болсон бол хадгаламж, итгэлцэл, бонд зэрэг тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын багц 18.6 тэрбум төгрөгт хүрэв.
2. Зээлийн багцын чанарыг сайжруулах, эргэн төлөлтийг тогтвортой байлгах зорилгын хүрээнд Группын хэмжээнд зээлийн багцыг өдөр тутамдаа хянаж, оновчтой маркетингийн кампанит ажлыг хэрэгжүүлэн харилцагчдын зээлийн эргэн төлөлтийг тогтвортой нэмэгдүүлсэн бөгөөд зээлийн багцаа тогтмол өсгөх бодлогыг барьсан болно. Ард Кредитын зээлийн багц жилийн туршид 10 хувиар нэмэгдэж 20.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд чанаргүй зээлийн багц нь 9.4 хувь буюу салбарын дундаж дүн болох 11.7 хувиас 230 пунктээр бага байна. Харин Ард Активын хувьд

зээлийн багцаа 64 хувиар нэмэгдүүлж 5.2 тэрбум төгрөгт хүргэсэн бол салбар дотроо хамгийн сайн чанарын зээлийн багцтай буюу чанаргүй зээлийн хувь хэмжээг 0.7 хувьд барьж ажилласан байна.

3. Компанийн үйл ажиллагаа, гүйцэтгэл дээр үндэслэн компанийн хөрөнгийн бүтцийг өөрчилж, Нэгдлийн хэмжээнд санхүүжилтийн зардлыг бууруулж ажиллалаа.

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд тайлант хугацаанд нийт хөрөнгө 80.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 3 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эдийн засаг болон зах зээлийн уналттай үед Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай нээлттэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэ тогтвортой байсан бөгөөд хувьцаа болон виртуал хөрөнгийн ханшийн өсөлтөөс нийтдээ 4.2 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Мөн Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшиж буй Монгол Шуудан болон Ард Даатгалын 1.3 хувийг тус тус борлуулсан бөгөөд Крипто Үндэстэн сан хаагдсанаар тайлант хугацаанд урт хугацаат хөрөнгө оруулалтын багц 757 сая төгрөгөөр буурч 67.5 тэрбум болсон байна. Хамгийн их өсөлтийг үзүүлсэн хөрөнгийн ангилал нь биет бус хөрөнгө бөгөөд жилийн хугацаанд 3.3 тэрбумаас 5.6 тэрбумаар өсөж 8.9 тэрбум төгрөг болсон байна. Виртуал хөрөнгийн бүртгэлд НББОУС 38 “Биет бус хөрөнгө” стандартын дахин үнэлгээний хандлагыг ашиглан бүртгэх аудитын зөвлөмжийн дагуу АрдКойныг биет бус хөрөнгөөр бүртгэв.

Харин манай баланс дээрх авлага болох 4.9 тэрбумаас 3.2 тэрбум төгрөгийг барагдуулж 1.7 тэрбум болж бууруулсан байна. Нийт өр төлбөр 21.5 тэрбум төгрөгөөс 24.5 тэрбум төгрөг болж, жилийн хугацаанд 3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Цар тахлын үед бэлэн мөнгөний гарах урсгалыг бууруулж, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар төлбөрүүд хуримтлагдаж дансны өглөг 1.9 тэрбумаар нэмэгдэж 4.5 тэрбум төгрөгт хүрэв. Харин компанийн богино болон урт хугацаат банкны эзэлийн дүн 3.3 тэрбумаас 1.8 тэрбумаар буурч 1.5 тэрбум төгрөг болсон бөгөөд богино хугацаат зээл тус бүр 1.1 тэрбум, урт хугацаат зээл 0.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үйл ажиллагаагаа тэлэх, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт хийх зорилгоор компанийн бондыг хаалттай хүрээнд гаргасан бөгөөд жилийн эцсээр 14.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болов. Мөн компанийн бондын 10.2 тэрбум нь төгрөгөөр төлөгдөх, 4.1 тэрбум төгрөг нь доллараар төлөгдөхөөр байна. Тайлант хугацаанд нийт 2.9 тэрбум төгрөгийн хүү, купон зэрэг санхүүгийн зардал гаргаснаар бидний эх үүсвэрийн дундаж өртөг 14.1 хувь болсон байна. Бид анх 2017 оны 3 сард хаалттай хүрээнд компанийн бонд гаргасан бөгөөд тухайн бонд нь жилийн 19.2 хувийн өгөөжтэй купонтой байв.

Өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 56.6 тэрбум төгрөгөөс 1.3 хувиар буюу 750 сая төгрөгөөр

буурч, 55.8 тэрбум төгрөгт хүрэв. Бидний хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц 24.1 тэрбум төгрөгөөс 27.3 тэрбум төгрөг болж, 3.2 тэрбум төгрөгөөр өссөн ч хуримтлагдсан ашиг 3.9 тэрбум төгрөгөөр буурсан нь эздийн өмчийг багасгав. Тайлант хугацаанд олгосон ногдол ашиг болох 1 тэрбум төгрөг нь хуримтлагдсан ашигт сөргөөр нөлөөлсөн болно.

2019 онд манай өр төлбөр нийт хөрөнгийн 27.5 хувийг эзэлж байсан бол 2020 онд энэхүү харьцаа нь 3 хувиар нэмэгдэж 30.5 хувь болсон байна. Хөрөнгийн бүтцийн хувьд нийт хөрөнгийн 84 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт, 11 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Харин өр төлбөрийн хувьд 73 хувь нь богино хугацаатай буюу 1 жилийн хугацаанд, 27 хувь нь урт хугацаатай буюу 1 жилээс дээш хугацаанд төлөгдөхөөр байна.

2020 онд нийт орлого 3.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 400 сая буюу 13.9 хувиар өссөн байна. Бид Ард Даатгал, Ард Кредит болон Монгол Шуудан зэрэг компаниудаас нийтдээ 1.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хүлээн авсан бөгөөд энэ нь өмнөх жилийн ногдол ашгийн орлогоос 775 сая төгрөг буюу 144 хувиар их байлаа. Мөн бидний үйл ажиллагаа өргөжиж, олон нийтэд хүрч ажиллах цар хүрээ нэмэгдэж, санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн ч цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд нийт зардал өмнөх жилээс 174 орчим сая төгрөгөөр буурч 7.1 тэрбум төгрөг болсон байна.


2019 оны дүнтэй харьцуулвал, үйл ажиллагааны зардал 42 хувиар буурч 2.7 тэрбум төгрөг, хүний нөөцийн зардал 35 хувиар өсч 1.6 тэрбум төгрөг болсон. Харин компанийн үйл ажиллагаа өргөжиж, сүүлийн жилүүдэд өрийн санхүүжилтийг тогтмол нэмэгдүүлснээр өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж төлөвлөгөөт дээд хэмжээндээ хүрэв. Ингэснээр санхүүгийн зардал 98 хувиар нэмэгдэж 2.9 тэрбум төгрөг болсон байна. Зардлын харьцааг дурдвал, үйл ажиллагааны зардал нийт зардлын 37 хувийг эзэлснээр өмнөх жилээс 26 пунктээр буурсан бол хүний нөөцийн зардал нийт зардлын 22 хувийг эзэслнээр 6 пунктээр, санхүүгийн зардал нийт зардлын 40 хувийг эзэлснээр 20 пунктээр нэмэгдсэн байна.

2020 оны санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитор болох Грант Торнтоны зөвлөмжийн дагуу СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр”-т заасан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэх өмчид оруулсан хөрөнгө оруулалтын шаардлагуудыг хэрэгжүүлснээр тайлант он болон өмнөх оны ашиг, алдагдалд томоохон өөрчлөлт оров. 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу Ард Санхүүгийн Нэгдэл нь үйл ажиллагаанаасаа 3.4 тэрбум төгрөгийн цэвэр ашгийг үйлдвэрлэж, хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт болох 2 тэрбумыг багтаасан нийт дэлгэрэнгүй орлого хугацааны эцэст 5.4 тэрбум төгрөг байсныг Грант Торнтон аудит олон улсын стандартын дагуу бидний үйл ажиллагааны чиглэлтэй уялдсан зөвлөмжийг

гаргаж, залруулснаар 2019 оны цэвэр ашиг 4.6 тэрбумын алдагдалтай, хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт 10 тэрбум болж нийт дэлгэрэнгүй орлогын дүнд өөрчлөлтгүй буюу 5.4 тэрбум төгрөгийг бүртгэсэн болно. Харин 2020 оны хувьд 4.0 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай байсан бөгөөд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өсөлт 4.2 тэрбум төгрөг болсноор нийт 200 сая төгрөгийн хэрэгжсэн, хэрэгжээгүй ашиг бүрдүүлсэн байна.

Тайлант үеийн дараах үйл явдлууд нь компанийн өсөлт, ашигт ажиллагаанд асар том түлхэц болж эерэгээр нөлөөлсөн бөгөөд аудитлагдаагүй дүнгээр 2021 оны эхний улиралд Ард Санхүүгийн Нэгдэл нь дангаараа 19.6 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 3 тэрбум төгрөгийн зардал бүртгэж, 1.7 тэрбум төгрөгийн орлогын татвар бүрдүүлснээр нэг улиралд 14.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Мөн Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшиж буй хувьцаа болон виртуал хөрөнгийн үнэ цэнийн өсөлтөөс 289.6 тэрбум төгрөгийн хэрэгжээгүй ашиг бүртгэснээр нийт 304.2 тэрбум төгрөгийн хэрэгжсэн, хэрэгжээгүй ашгийг бүрдүүлжээ. Энэхүү ашиг нь эздийн өмчийг нэмэгдүүлж 377 тэрбум болгосоноор компанийн цэвэр хөрөнгө улирлын хугацаанд 5 дахин нэмэгдлээ. Мөн нийт хөрөнгө 4.5 дахин өсч 437 тэрбум төгрөг болсон бөгөөд урт хугацаат хөрөнгө оруулалтын багц 268 тэрбум, биет бус хөрөнгө 149 тэрбум төгрөг болж өссөн нь голлох хүчин зүйл байв.

Хөрөнгө оруулалтын багц



(2020 оны 12 сарын 31-ний байдлаар)

Нээлттэй компани

Ард Санхүүгийн Нэгдэл

Холбоотой талууд

Ард Даатгал (MSE: AIC)

2020 оны онцлох үйл явдал

- Ковид-19 цар тахлын хөл хорионы үед ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж шинэ даатгалын бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж 2,069 болов.
- Улаанбаатар хотод улсын их дэлгүүрт учирсан галын үүдэлтэй хохирол, мөн гадаад, дотоодын ачааны хохирол зэрэг хэд хэдэн томоохон хохирлуудыг амжилттай нөхөн төлөв.
- Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП 20 индексэд гурван жил дараалан багтаж чадав.
- Харилцагчийн менежментийн (CRM) систем нэвтрүүлэв.
- Монгол Улсад анх удаа “Хүнд өвчний даатгал”-ын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ
- Ард Санхүүгийн Нэгдэл болон бусад охин компаниудтай хамтран Хөрөнгө Оруулагч Үндэстэн-Хөдөө орон нутагт аянг амжилттай хэрэгжүүлж 21 аймгаар үйл ажиллагаагаа танилцуулав.
- Их Британи Улсын “The Chartered Insurance Institute”-ээс зохион байгуулсан сургалтад хамрагдав.
- Нийт 5 жил, нээлттэй хувьцаат компани болсноос хойш 3 дахь жилдээ дараалан хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилав.
- Ард Лайф ХХК-тай хамтран дэлхийн жишигт хүрсэн тэтгэврийн сангийн тогтолцоог нутагшуулах зорилгоор “Гурвалсан тэтгэврийн хуримтлал”-ын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.
- АрдКойн урамшуулалт хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жил осол гаргаагүй осолгүй, манлай жолооч, даатгуулагчдадаа АрдКойн олгов.
- Цахим даатгалын шийдлийг нэвтрүүлэн, Ард Аппад даатгалын цэс шинээр нэмэгдэж, Апп ашиглагч хэн бүхэн тээврийн хэрэгсэл, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой болов.
- Дэлхийд алдартай телевизийн нэвтрүүлэг болох Аппрентис Монгол бизнесийн шоуг Монгол Улсад анх удаа Ард Санхүүгийн Нэгдэл зохион байгуулсан бөгөөд тус шоунд АрдМэнд эрүүл мэндийн даатгалаа танилцуулан амжилттай хамтран ажиллав.

Үйл ажиллагааны тайлан

Ард Даатгал ХК нь 2020 онд үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн 21 салбар нэгж, төлөөлөгчийн газар, системийн нөлөө бүхий 5 арилжааны банк, олон улсын болон дотоодын 70 гаруй брокер, мэргэжлийн оролцогч зуучлагч, олон тооны банк бус санхүүгийн байгууллага, 100 орчим даатгалын төлөөлөгчдөөрөө дамжуулан улс орон даяар даатгалын үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Компанийн хувьд даатгалын үйлчилгээ өргөжин тэлж борлуулалтын орлого 15.8 тэрбум хүрч түүхэнд байгаагүй хэмжээнд хүрлээ.

Ард Даатгал компани нь өнгөрсөн хугацаанд Монгол Улсын өнцөг булан бүрт хүрч ажиллаж чадсан бөгөөд 2020 оны байдлаар нийтдээ 190 гаруй мянган даатгуулагчийг даатгалд хамруулаад байгаа төдийгүй үүнээс 2 мянга гаруй байгууллагатай 15 мянга гаруй гэрээ байгуулж улс орны баялаг бүтээж байгаа бүхий л салбарыг хамруулан даатгалын үйл ажиллагаагаа хүргэн ажиллаж байгаад компанийн хамт олон бахархаж байдаг юм. Тухайлбал:

- | | |
|---|--|
|  Дэд бүтэц, зам тээвэр |  Банк санхүү, даатгал |
|  Иргэний нисэх, агаарын тээвэр |  Аялал жуулчлал, спорт |
|  Барилга угсралт |  Эрүүл мэнд |
|  Үл хөдлөх хөрөнгө |  Мэдээлэл технологи, харилцаа холбоо |
|  Эрчим хүч, уул уурхай, газрын тос |  Төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагууд |
|  Хөдөө аж ахуй |  Эрдэм шинжилгээ, боловсрол, хууль эрх зүй |
|  Худалдаа үйлчилгээ |  Олон улсын байгууллага, Элчин сайдын яам |
|  Хөнгөн ба хүнд үйлдвэрлэл | |
|  Батлан хамгаалах, цэрэг цагдаа, онцгой байдал | |

Харилцагчдаас дурдвал: Энержи Ресурс, Оюу Толгой, Эрдэнэт УБҮ, Худалдаа Хөгжлийн банк, Төрийн банк, Хаан банк, Иргэний Нисэхийн Ерөнхий газар, Петровис, Магнай Трейд ХХК, Макс Групп, Онцгой байдлын Ерөнхий газар, Монцемент, М-Си-Эс Холдинг, салбар болон охин компаниуд, Шангрила зэрэг Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа аж ахуйн нэгж, компаниудтай бид хамтран ажилладаг. Бид давхар даатгалын хувьд ХБНГУ-ын Hannover Re давхар даатгалын компанитай 5 дахь жилдээ хамтран ажиллаж (Whole Account Excess of Loss) Treaty гэрээгээр нэгж даатгалын зүйлийн хувьд 2.0 сая ам.долларын хариуцлагын хязгаар бүхий хамгаалалт авч, 2.0 сая ам.доллароос давсан гэрээ болгоныг тухай бүрт нь (Facultative) давхар даатгалд хамруулан, уг гэрээ нь манай эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад найдвартай даатгалын хамгаалалт болж өгч байна. Мөн олон улсын эрүүл мэндийн даатгал болон гадаад зорчигчдын даатгалыг Quota Share давхар даатгалд хамруулж дэлхийн бүх оронд үйлчлэх даатгалын цогц хамгаалалтыг харилцагчдадаа үзүүлжээ.

Ард Даатгал ХК-ийн давхар даатгуулсан эрсдэлийн 40 хувийг Азийн зах зээл, 36 хувийг Европын зах зээл, 9 хувийг ОХУ-н зах зээл мөн 15 хувийг Монгол Улсын давхар даатгалын зах зээлд AM Best A++ болон B+ үнэлгээ бүхий давхар даатгагч нарт эрсдэлийг тараан байршуулж ажилласан байна.


2020 онд Ард Даатгал ХК нь нөхөн төлбөрийн үйлчилгээгээр 4,824 даатгалын тохиолдолтой холбоотой 4.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж, даатгуулагчдын өмнө хүлээсэн даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ. Тайлант хугацаанд компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 11.6 хувь буюу 547 сая төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж үлдсэн хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн байна. Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн 62 хувь нь хөрөнгийн даатгалд, 38 хувь нь эрүүл мэндийн даатгалаар байна.

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

MSE: AIC	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Өдрийн дундаж арилжаа	Нийт арилжааны дүн	Арилжигдсан тоо ширхэг
2020/01/01 - 2020/12/31	₮798.00	₮800.00	₮630.00	₮799.96	0.25%	₮5,054,302	₮1,177,652,456	1,643,406
2020/12/31 - 2021/03/31	₮785.00	₮1,590.00	₮705.00	₮1,455.00	85.35%	₮109,316,601	₮5,800,454,474	5,509,069

	2019	2020	2021 Y1		2019	2020	2021 Y1
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,637	2,069	8,142	Хаалтын үнэ	₮799.95	₮799.96	₮1,455.00
Нийт хувьцааны тоо	25 сая	25 сая	25 сая	P/E - Үнэ/Ашиг	11.64	9.31	5.45
Зах зээлийн үнэлгээ	₮19,999 сая	₮19,999 сая	₮36,375 сая	P/B - Үнэ/Дансны үнэ	1.69	1.50	1.82

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Ард Кредит (MSE: ADB)

2020 оны онцлох үйл явдал

- Монголын Хөрөнгийн Биржийн 2020 оны ТОП-20 индексн сагсанд Ард Кредит ББСБ ХК багтав.
- Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Г.Тэлмэн томилогдон ажиллаж эхлэв.
- 2019 оны цэвэр ашиг болох 2.2 тэрбум төгрөгийн 50% буюу 1.1 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж 4 сарын 30-нд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас хамгийн түрүүнд ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдэдээ тараав.
- Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих BEST хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж эзэлдэгчдийн боловсролын чиглэлээр ажиллаж эхлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг анх удаа цахимаар 85.21% ирцтэйгээр амжилттай зохион байгуулав.
- Монголбанкнаас Ард Кредит ХК-д Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосноор банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв.
- Япон улсын Крауд Кредит сангийн санхүүжилтийн эргэн төлөлтийг өөрийн эх үүсвэрээр амжилттай гүйцэтгэв.
- Хөрөнгө Оруулагч Үндэстэн орон нутагт хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор, Өвөрхангай аймгуудад Fast Cash цахим зээл олгож эхлэв.
- ЕвроЖайро Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 10 сарын 2-ны өдөр Монгол Шуудан ХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлэв.
- АСН+ (Автомат Клиринг Хаус) банк хоорондын шууд гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлэв.

Үйл ажиллагааны тайлан

2020 он дэлхий дахинд нийгэм, улс төр, бизнесийн салбарт гэнэтийн бөгөөд томоохон өөрчлөлтүүдийг авчирсан түүхэн цаг үе байсан бол Ард Кредит ХК (MSE: ADB) цар тахлын үед харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангахын зэрэгцээ санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангахуйц шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг технологийн шилдэг шийдлүүдтэй хослуулан нэвтрүүлж, салбартаа манлайлан ажиллалаа.

Хэдийгээр нээлттэй хувьцаат компани болоод жил хүрэхгүй хугацаа өнгөрч байсан ч Ард Кредит нь Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекст багтаж, хувьцаа эзэмшигчдэдээ 2019 оны цэвэр ашгийн 50 хувь болох 1.1 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараасан нь олон нийт, хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа нэр төртэй биелүүлсэн хэрэг байв.

2020 онд компанийн нийт хөрөнгийн хэмжээ 28.4 хувиар өсч 29.7 тэрбум төгрөгт, цэвэр зээлийн багцын хэмжээ 6.7 хувиар өсч 18.9 тэрбум төгрөгт хүрснээр 2.1 тэрбум төгрөгийн нийт дэлгэрэнгүй ашигтай ажиллалаа.

Монголбанкнаас Цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрөл авч, АрдКэш цахим мөнгийг хэрэглээнд нэвтрүүлсэн, АСН+ (Автомат Клиринг Хаус) системд амжилттай нэгдсэн, олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн зэрэг нь компанийн онцлох амжилтууд төдийгүй эдгээр амжилтууд нь Ард Апп хэрэглэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 44.1 хувиар өсч, 637 мянгад хүрэхэд жин дарж нөлөөлөв.

АрдКэш нь төгрөгт, төгрөг нь АрдКэшд чөлөөтэй хөрвөх боломжтой байдаг. Ингэснээр Ард Аппын хагас сая хэрэглэгчдэд зээл авах, үнэт цаасны арилжаанд оролцох, онлайн худалдаа хийх, мөнгө гуйвуулах, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн олон төрлийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай авах боломжийг албажуулсан онцгой үйл явдал боллоо.

Мөн банк хоорондын төлбөр тооцооны АСН+ (Автомат Клиринг Хаус) системд нэгдсэнээр Ард Аппын хэрэглэгчид 3 сая хүртэлх бага үнийн дүн бүхий гүйлгээг бодит цагийн горимоор, 24/7 зарчмаар тасралтгүй, түргэн шуурхай хийх боломжтой болсон билээ.

Үүнээс гадна, Ард Кредит ХК стратегийн түнш Монгол Шуудан ХК-тай хамтран дэлхийн өнцөг булан бүрт байршилтай, 500 мянган салбар нэгж бүхий санхүүгийн байгууллагууд, 4 тэрбум хүнийг төлбөр тооцооны дэд бүтцээр холбодог Eurogiro байгууллагын “Санхүүгийн супермаркет” системд холбогдож олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.

Ингэснээр АНУ, ОХУ, БНСУ, Австрали, Турк, Их Британи зэрэг дэлхийн 50 гаруй оронд суугаа мянга мянган харилцагчид Ria, KoronaPay, Small world, PostalPay зэрэг дэлхийн томоохон мөнгөн гуйвуулгын операторуудын салбараас Монгол Улсад суугаа дотны хүндээ түргэн шуурхай мөнгө шилжүүлэх боломжтой болсон.

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА


MSE: ADB	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Өдрийн дундаж арилжаа	Нийт арилжааны дүн	Арилжигдсан тоо ширхэг
2020/01/01 - 2020/12/31	₮80	₮82	₮60	₮82	3.27%	₮9,110,974	₮2,190,301,292	29,765,830
2020/12/31 - 2021/03/31	₮79	₮275	₮77	₮250	3.2x	₮156,492,917	₮9,505,176,103	70,905,930

	2019	2020	2021 У1		2019	2020	2021 У1
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,500	2,139	10,071	Хаалтын үнэ	₮82	₮82.1	₮250.23
Нийт хувьцааны тоо	280 сая	280 сая	280 сая	P/E - Үнэ/Ашиг	10.5	18.1	20.8
Зах зээлийн үнэлгээ	₮22,952 сая	₮22,459 сая	₮69,060 сая	P/B - Үнэ/Дансны үнэ	2.2	2	2.3

Компанийн голлох бүтээгдэхүүнүүдийн нэг болох Fast Cash цахим зээлийг Баянхонгор, Өвөрхангай аймгуудад олгож эхэлсэн нь цаашид зээлийн үйлчилгээг Монгол орны өнцөг булан бүрт хүртээмжтэй үзүүлэх эхлэл болов.

Энэхүү тайлан таны гарт хүрч буй цаг мөчид Ард Кредит ХК 10,000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй болж, хувьцааны үнэ түүхэн дээд ханшид хүрч, Ард Апп 1.2 сая гаруй харилцагчтай болоод байгааг дуулгахад таатай байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Ард Секюритиз

2020 оны онцлох үйл явдал

- Ард Секюритиз ҮЦК Монголын Хөрөнгийн Бирж дээрх хоёрдогч зах зээлийн арилжааны дүнгээр салбараа тэргүүлээ.
- Ард Секюритиз ҮЦК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Э.Амарбаясгалан томилогдлоо. Амарбаясгалан нь санхүүгийн салбарт 20-иод жил ажилласнаас 10-аад жилийг хөрөнгө оруулалтын чиглэлээр ажилласан туршлагатай билээ.
- Гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл Санхүүгийн Зохицуулах Хорооноос авч Ард Секюритиз ҮЦК харилцагчдадаа Interactive Brokers гадаад арилжааны платформ дээр данс нээж өгч, гадаад арилжаанд оролцоход нь зуучилж эхэллээ.
- Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Степ Голд (TSE:STGO) компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлэх ажлын андеррайтераар сонгогдлоо.
- Хаалттай бондын андеррайтераар ажиллаж, нийт 7.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай босголоо.
- Монголын Хөрөнгийн Бирж дээр гарсан анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сангийн андеррайтераар ажиллаж олон нийт болон үндэсний тэргүүлэгч компаниудаас 4.75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлж чадлаа.

Үйл ажиллагааны тайлан

2020 онд Ард Секюритиз ҮЦК -ийн харилцагчид Ард Аппаараа үнэт цаасны дансаа нээх, Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй бүхий л хувьцааг авах, зарах, зах зээлийн судалгаа шинжилгээтэй танилцах, хөрөнгө оруулалтын өгөөжөө тооцох, нээлттэй бондын захиалга өгөх бүрэн боломжтой боллоо.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржээр анхдагч болон хоёрдогч зах зээлийн 23 тэрбум төгрөгийн арилжаа хийгджээ. Үүнээс 97 тэрбум төгрөгийн хувьцааны хоёрдогч арилжаа явснаас 23 тэрбум буюу нийт арилжааны 24 хувийг Ард Секюритиз ҮЦК дангаараа бүрдүүлжээ.

Андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд Ард Секюритиз ҮЦК нь харилцагч компаниудад санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, 7.1 тэрбум төгрөгийн санхүүжилт татаж өглөө. Компанийн мэргэжилтнүүд танхимын болон цахим сургалтуудыг тогтмол хийдэг ба хөдөө орон нутгаар “Хөрөнгө Оруулагч Үндэстэн” аян зохион байгуулж сургалтуулдыг амжилттай хийлээ.


Ард Секюритиз ҮЦК Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Степ Голд (TSE:STGO) компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр давхар бүртгүүлэх ажилд андеррайтераар сонгогдлоо. Энэ ажлын хүрээнд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс таван тэрбум төгрөг татан төвлөрүүлэх бөгөөд Монголын иргэдэд баялгийнхаа эзэд болоход хялбар, зардал багатай гарцыг нээхээр ажиллаж байна.

Ард Менежмент ҮЦК-ийн гаргасан Үндэсний Хувьчлалын Сан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн андеррайтераар ажиллаж нийт захиалгын 83 хувь буюу 1,845 харилцагчийн 3.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. IPO-нд оролцсон харилцагчдын 50 хувь нь Ард Аппаар дамжуулан захиалгаа өгчээ. Ард Секюритиз Ард Менежменттэй хамтран ажиллах гэрээний хүрээнд ХОС-н удирдлагад дотоод болон олон улсын захын хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээ тогтмол бэлдэж өгдөг бөгөөд ХОС уг судалгаан дээр үндэслэн хөрөнгө оруулалтуудыг үе шаттайгаар хийсээр 2020 оны 12 сарын сүүлээр 4.42 хувийн буюу жилээр тооцвол 25.6 хувийн өгөөжтэй ажиллалаа.

Ард Секюритиз ҮЦК нь ойрын ирээдүйд тэргүүлэгч хөрөнгө оруулалтын банк болохоор ажиллаж байгаа бөгөөд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын зөвлөгөө, гадаад арилжаа, андеррайтингийн үйл ажиллагаагаа тэлэх төлөвлөгөөтэй байна.

Банк, хувийн тэтгэврийн сангийн реформ, даатгалын салбарын өөрчлөлт болон олон нийтийн хөрөнгийн захад нэгдэх сонирхол нэмэгдэж байгаа зэрэг нь Ард Секюритиз ҮЦК-ийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Ард Лайф

2020 оны онцлох үйл явдал

- 20 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж хуваарилав
- Хувийн тэтгэврийн хуулийн төслийг өргөн барих ажилд оролцов
- Харилцагчдын тоо 763 хувиар өсөв

Үйл ажиллагааны тайлан

2020 он Ард Санхүүгийн Нэгдэл ХК (Ард)-ийн хувьд бусад үйл ажиллагаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгжүүдийн ижил хүнд цаг үе тохиосон хэдий ч бид цахим орчныг боломж мэт харж Ард Аппаараа дамжуулан бүхий л охин компаниуддаа өсөлтүүдийг авчирч чадсан нь өнгөрсөн оны шалгуур мэт даваа байлаа. Ард Лайф ХХК (Ард Лайф)-ийн хувьд ч тэр харилцагчдын тоо, хөрөнгө оруулалтын үнэлгээ, нийт тэтгэврийн хуримтлал гээд голлох үзүүлэлтүүд дээр урьд өмнө үзүүлж байгаагүй түүхэн өсөлтүүдийг үзүүлж чадсан жил өнгөрлөө.

Оны эхний улиралд багтаан Ард Лайф нь хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх нөхцөлтэй хуримтлалын данс үүсгэсэн харилцагч нартаа өмнөх жилийн хөрөнгө оруулалтын өгөөжийг тараан хуваарилдаг бол бид харилцагчдадаа жилийн 20 хувийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хуваарилсан амжилттай 2020 оныг эхлүүлэв.

2020 оны эхний хагаст Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд шинээр 5 гишүүн томилогдож, тэдгээр дунд хөрөнгийн болон даатгалын зах зээлд чамгүй туршлага хуримтлуулсан Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах, Ардын Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Э.Амарбаясгалан,


Ард Лайфын Гүйцэтгэх захирал Б.Гантулга, Нэксүс ББСБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Оюун-Эрдэнэ, ING Bank Монголиа-ийн төлөөлөгч Э.Сангаамаа нар багтав. Шинэ удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр хөрөнгийн удирдлагын оновчтой шийдвэрүүдийг гаргаж, Ард Лайфын хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц нь 2020 оны байдлаар 2.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 148 хувиар өсөв.

Ард Лайф нь цар тахлын үед ч тэр сургалтуудаа үргэлжлүүлж, албан байгууллага болон иргэдэд цахимаар мэдээллээ цаг алдалгүй хүргэж чадсанаар хамтран ажилладаг байгууллагын эгнээнд 34 албан байгууллага болон тэдгээрийн ажиллагсад багтаж байна. Ард Аппыг ашиглан иргэдэд тэтгэврийн хуримтлал нээх боломжийг бий болгож өгснөөр сайн дурын үндсэн дээр хуримтлал үүсгэж буй харилцагчдын тоо 2020 оны эцэст 10,447 болж, жилийн дотор 763 хувиар өссөн нь Ард Лайфын хувьд цахим орчныг оновчтой ашиглаж, иргэддээ хүрч ажилласан амжилтыг илэрхийлж байна. Харилцагчдын тоо өссөнөөр Ард Лайф дахь тэтгэврийн хуримтлалын дүн ч өмнөх жилийн эцсээс 100 хувиар өсөж, 3.4 тэрбум төгрөгт хүрэв.

Мөн Ард Лайф нь нийгмийн ажилд идэвхтэй оролцдог ба 2020 онд чухалчилж оролцож, хувь нэмрээ оруулсан томоохон ажил нь яах аргагүй – тэтгэврийн тогтолцооны шинэчлэл хийх ажлын хэсэгт багтан, ард иргэдэд хувийн тэтгэврийн талаарх мэдлэг боловсрол олгох, хувийн тэтгэврийн хуулийн төсөлд гаднын туршлага, Монгол Улсын зах зээлд тохиромжтой тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүний нөхцөлүүдийг тусгаж өгөх байв. Энэхүү ажлын хүрээнд бид Хөрөнгө Оруулагч Үндэстэн аяныг зохион байгуулж, Монгол Улсын 14 аймгуудыг тойрч, ард иргэдэд тэтгэврийн хуримтлалын ач холбогдол, түүний ирээдүйн үр ашиг, хойч үед өвлөгдөх хөрөнгийн талаар мэдлэг олгохын сацуу санхүүгийн боловсролыг түгээж ажилласан. Энэ мэт нийгэмд хүргэдэг сургалт,

танилцуулгууд маань үр дүнгээ үзүүлж, нийгэм тэтгэврийн тогтолцоог шинэчлэх ажлыг хойч үед эерэг нөлөө авчрах томоохон өөрчлөлт хэмээн чухалчилж үздэг болсон билээ. Хувийн тэтгэврийн хуулийн төслийн хүрээнд бид Улсын Их Хурал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн Хөгжлийн Банкны төслүүд дээр тус тус ажиллаж, хуулийн төслийг боловсруулахад идэвхтэй хувь нэмрээ оруулж чадсан билээ. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нийт иргэдийн эрх ашигт нийцсэн, ирээдүйг нь баталгаажуулсан, урт удаан, эрүүл энх, жаргалтай амьдрах итгэлийг өгсөн, Монгол хүн эх нутгийнхаа баялагт эзэн суух үүд хаалгыг нээх түүхэн өөрчлөлт авчирна гэдэгт бид итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Ард **Актив**

2020 оны онцлох үйл явдал

- Нийт хөрөнгийн хэмжээгээрээ салбартаа тэргүүлэх 4 дэх хадгаламж, зээлийн хоршоо болж үйл ажиллагаагаа өргөжүүлэв.
- Бүх гишүүдийн хурлаа 23.5 хувийн ирцтэйгээр 3-р сард цахимаар амжилттай зохион байгуулав.
- Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн тоог 45 хувиар нэмэгдүүлж 1,062 гишүүнтэй болов.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 18 хувь нэмэгдүүлж 949 сая төгрөгт хүргэв.


Үйл ажиллагааны тайлан

Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо нь анх 2004 онд Траско хадгаламж, зээлийн хоршоо нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. 2013 онд Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо болж нэрээ сольсон бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлээс хөрөнгө оруулалт хийж эхэлсэн.

Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо нь 2020 онд нийт хөрөнгөө 66 хувиар нэмэгдүүлж 6.9 тэрбум төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгөө 18 хувиар нэмэгдүүлж 919 сая төгрөгт хүргэлээ. Нийт орлогоо 21 хувиар нэмэгдүүлж 992 сая төгрөгийн орлоготой, 42 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2020 онд 5.6 тэрбум төгрөгийн хадгаламж шинээр татан төвлөрүүлж 5.4 тэрбум төгрөгийн хадгаламжтай, 5.9 тэрбум төгрөгийн шинэ зээл олгон 5.2 тэрбум төгрөгийн зээлийн багцтай болсон. Орлогын хүрэлцээ сайн, зээлийн барьцаа хөрөнгө хүрэлцээтэй, сайн зээлийн түүхтэй гишүүддээ хүү багатай зээл олгох бодлогыг баримтлан ажилласнаар чанаргүй зээлийн хувь хэмжээг салбарын дунджаас харьцангуй бага буюу 0.7 хувьд барьж ажилласан байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Ард Менежмент

2020 оны онцлох үйл явдал

- Монгол Улсын анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сангийн хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлж, үйл ажиллагааг эхлүүлэв.
- Хөрөнгө оруулалт итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд Үндэсний Хувьчлалын Сангийн хөрөнгийг удирдаж, жилийн 25.6 хувийн өгөөжтэй ажиллав.
- Булган Ундрага ХК-ийг худалдан авах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулав.

Үйл ажиллагааны тайлан

2020 он Ард Менежмент компанийн хувьд төдийгүй Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд онцлог жил байлаа. Ард Менежмент ҮЦК ХХК нь 2019 онд Монгол Улсын анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан болон Үндэсний Хувьчлалын Сан (цаашид ХОС гэх)-г үүсгэн байгуулж байсан бол 2020 онд ард иргэдээсээ 4.75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татаж, үйл ажиллагааг нь эхлүүллээ. Ингэснээр салбартаа анхдагч нь байж, Монгол Улсад хамтын хөрөнгө оруулалтын сан болон мэргэжлийн хөрөнгө оруулагч үүсэх үндэс суурийг тавилаа.

ХОС нь Монголын болон олон улсын зах зээл дээр арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж, нэгж эрх эзэмшигчдэдээ ашгаа хуваарилах зарчмаар ажиллах зорилготой бөгөөд 2020 оны 10 сарын 5-ны өдөр анх олон нийтэд нэгж эрхээ санал болгосон билээ. Уг нэгж эрх нь хамгийн эрэлттэй

хөрөнгө оруулалтын хэрэгсэл болж, нийтдээ 2,245 хөрөнгө оруулагчаас 5.5 тэрбум төгрөгийн нэгж эрх худалдан авах захиалга ирсэн байна. Энэ нь санал болгосон үнийн дүнгээс даруй 33 хувиар давсан үзүүлэлт бөгөөд, нийт хөрөнгө оруулагчдадаа хувь тэнцүүлэх замаар нэгж эрхийг хуваарилсан билээ.

Мөн Ард Менежмент нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд ХОС-ийн хөрөнгийг удирдаж, үйл ажиллагааг жигдрүүлэх, багцын өгөөжийг зорьсон төвшинд хадгалахын тулд дотоод болон олон улсын зах зээл дээр судалгаа шинжилгээ хийж уг судалгаан дээр үндэслэн хөрөнгө оруулалтуудыг үе шаттайгаар хийсээр 2020 оны 12 сарын сүүлээр ХОС нь 4.42 хувийн өгөөжтэй буюу жилээр тооцвол 25.6 хувийн өгөөжтэй ажилласан байна. Ингэснээр ард иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үр ашигтай хөрөнгө оруулалтууд хийж, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулагчдадаа

жилийн 25.6 хувийн өгөөжтэй ажиллаж, хадгаламжийн хүү буурч буй энэ цаг үед хөрөнгийн зах зээлээс өндөр өгөөж хүртэх боломжийг хөрөнгө оруулагчдадаа олгосон билээ.

Ард Менежментийн үндсэн үйл ажиллагаа нь Хөрөнгө оруулалтын сангууд үүсгэн байгуулах, түүний хөрөнгийг удирдах бөгөөд үүнээс гадна үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх зорилгоор Булган Ундрага ХК-ийг худалдан авах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулснаар 2020 оны 12 сарын 17-ны өдөр Ард Бит ХХК нь Булган Ундрага ХК-ийн 99.9 хувийн эзэмшигч боллоо.

Булган Ундрага ХК нь үйл ажиллагаа нь зогссон, санхүүгийн чадваргүй компани байсан бөгөөд Ард Бит ХХК нь тус компанийн үйл ажиллагааг

Монгол Улсад төдийгүй дэлхий даяар өргөжин тэлж буй блокчэйн технологи болон криптовалютын чиглэлээр үйл ажиллагааг нь өргөжүүлэхээр зорьж байгаа болно. Мөн Ард Менежмент нь толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нэлээдгүй ажил хийж гүйцэтгэн 2020 оныг амжилттай үдлээ. Үүнд:

- Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Жинст Увс ХК-иудыг нэгдэх ажлын хүрээнд 2 компанийн үнэт цаасын дансыг нэгтгэх ажлыг зохион байгуулав.
- Ард Холдингс Интернэшнл ХХК болон И Ай Ти ХХК зэрэг компанийг хөрөнгөжүүлэх, Ард Холдингсын хувьцааг шилжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулав.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2020 онд Ард Менежмент 224 сая төгрөгийн орлоготой, 295.3 сая төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд татварын дараах алдагдал 61.4 сая төгрөг, нийт дэлгэрэнгүй орлого 575 сая төгрөг байна. Тайлант онд Ард Менежмент нь бүтэц, зохион байгуулалтаа өөрчилж, үндсэн үйл ажиллагаандаа төвлөрч ажилласан нь үндсэн бус үйл ажиллагааны

орлогыг бууруулж, компанийн хүний нөөцийн зардлыг нэмэгдүүлсэн байна. Оны эцэст толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК-иас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь нийт дэлгэрэнгүй орлого өсөхөд голлон нөлөөлсөн байна.



Ард Бит

2020 оны онцлох үйл явдал

- АрдКойныг бусад бирж дээрээс амжилттай эргэн татах хөтөлбөрийг хэрэгжүүлж 17 сая АрдКойныг амжилттай эргэн татав.
- АрдКойн эзэмшигчдийн тоо 286,117 хүрэв.
- АрдКойноор AARD, ADB болон AIC хувьцааг SWAP хийх хөтөлбөр амжилттай хэрэгжиж 4.4 сая АрдКойноор SWAP хийгдэв.
- Digital Assets Exchange (DAX) буюу АрдКойн өөрийн төрөлх биржийн туршилтын хувилбарыг амжилттай нээв.

Үйл ажиллагааны тайлан

2020 онд дотоод компаниудын үйл ажиллагааг дэмжих ажлууд хийгдэж Ард Лайф компанитай хамтран АрдКойн эзэмшигчдэд тэтгэврийн хуримтлал санал болгосон бөгөөд 7’047 харилцагч шинээр хуримтлалтай боллоо. Үүнд мөн АрдКойноороо анхны орлогоо хийх боломжийг олгож 68 сая АрдКойн орлогодсон. Ард Шоптой хамтран ажилласнаар 1’000 харилцагч 8.2 сая АрдКойноор хөнгөлөлт эдэлж худалдан авалтаа амжилттай хийсэн нь Ковидын үед онлайн худалдааг дэмжихэд тус нэмэр боллоо. АрдКойныг урт хугацаанд хадгалж байгаа хүмүүсийг урамшуулж HODL хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн

бөгөөд 1’340 хүн 165 сая АрдКойныг Ард Апп дээрх өөрсдийн АвДартаа хадгалж байна. АрдКойны хэрэглээг нэмэгдүүлж цаашдын Security Token-ы арилжааны туршилтыг амжилттай хийж Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал болон Ард Кредит компаниудын хувьцааг SWAP хөтөлбөрийн хүрээнд 4.4 сая АрдКойноор арилжсан. 2020 оны 12 сард өөрийн төрөлх бирж болох Digital Assets Exchange амжилттай үйл ажиллагаагаа эхлүүлсэн үүний хүрээнд Ард Апп дотроо АрдКойны арилжихаас гадна Биткойн болон монголын анхны Security Token (ARDT)-г өөрийн урамшууллын оноогоороо авах боломжтой болсон.

Тоон үзүүлэлт

Шинэ харилцагчдад олгосон урамшуулал

№	Бүтээгдэхүүн	Харилцагчийн тоо	Олгосон АрдКойн
1	Бүртгэлийн урамшуулал	147,654	108,572,400.00
2	И-мэйл баталгаажуулалт	19,803	2,265,560.00
3	Найзаа урих	79,984	94,800,500.00
4	Facebook баталгаажуулалт	21,854	2,645,000.00
Топ хувьцаа эзэмшигчид		269,295	208,283,460.00

(2020 оны 12 сарын 31-ний байдлаар)

Бүтээгдэхүүн үйлчилгээнд олгосон урамшуулал

№	Компани	Харилцагчийн тоо	Олгосон АрдКойн
1	Ард Кредит	233,556	33,968,155.52
2	Ард Даатгал	1,728	677,092.31
3	Ард Секюритиз	23,061	7,740,966.92
4	Ард Лайф	6,049	10,582,489.80
5	Ард Актив	193	1,651,473.02
6	АрдШоп	1,019	679,370.42
7	Ард Холдингс	1,511	9,600,890.00
Нийт		267,117	64,900,437.99

(2020 оны 12 сарын 31-ний байдлаар)

2020 онд хийгдсэн АрдКойны урамшуулал хөтөлбөрүүд

№	Хөтөлбөрийн нэр	Оролцогчдын тоо	АрдКойны хэмжээ
1	HODL	1,340	165,277,327
2	SWAP	12	4,466,897
3	Хуримтлалдаа орлого хийх	7,047	68,241,751
4	Хувьцаатай хүүхэд	10	2,880,000
5	Худалдан авалт (ardshop)	997	8,222,551

АрдШоп

2020 оны онцлох үйл явдал

- Технологи болон үйлчилгээний чанарыг шинэ түвшинд авчрахаар Б.Ариунаа Гүйцэтгэх захирлаар томилогдов.
- Ковид-19 цар тахал, хөл хорио, хэрэглэгчийн зан төлвийн өөрчлөлт онлайн худалдааны өсөлтийг эрс хурдасгав.
- Хувьцаа эзэмшигчид нэмэлт хөрөнгө оруулалт хийв.
- Бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 2019 онтой харьцуулахад 137 хувиар өсөв.

Үйл ажиллагааны тайлан

Ард Санхүүгийн Нэгдлийн Маркетинг эрхэлсэн захирлаар ажиллаж байсан Б.Ариунаа 2020 оны гуравдугаар улиралд Эм И Си Партнерс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж эхлэв. Тэрээр АрдШоп цахим худалдааны платформын стратегийн зорилтыг “Технологийн дэвшлийг ашиглаж хэрэглэгчдэд хамгийн сайн үйлчилдэг онлайн дэлгүүр болно” хэмээн тодорхойлов. Нэг талдаа хэрэглэгчдэд онлайнгаар худалдан авах бүтээгдэхүүний өргөн сонголтыг санал болгодог, нөгөө талдаа бизнес эрхлэгчдэд олон зуун мянган үйлчлүүлэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ цахимаар хүргэх боломжийг олгодог тус платформ нь 2020 онд бүртгэлтэй хэрэглэгчдийн тоогоо 137 хувиар нэмэгдүүлж 254,000 хүргэжээ. 2021 оны 4 дүгээр сарын байдлаар АрдШопын хэрэглэгчдийн тоо 700,000 давсан байна.

Эм И Си Партнерс ХХК нь технологио шинэ түвшинд хөгжүүлэх, компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд өөрийн хувьцаа эзэмшигчдэдээ нэмэлт хувьцаа санал болгож нэмэлт хөрөнгө оруулалт татсан ба тус компанид Ард Холдингсын эзэмшдэг хувь 40% байсан нь өсөж 61.24% болов.


АрдШоп онлайн дэлгүүрийн шинэ мобайл хувилбарын хөгжүүлэлтийн ажил 2020 оны IV улиралд эхэлсэн бол 2021 оны 1 дүгээр сард хэрэглээнд нэвтэрсэн байна. Энэхүү шинэ хувилбар нэвтэрснээр АрдШопын хэрэглэгчийн интерфэйс ашиглахад хялбар, илүү хурдан болсон бөгөөд хэрэглэгч хүссэн бүтээгдэхүүнээ хайлт болон ангиллын системийг ашиглан олоход маш хялбар болсон нь хэрэглэгчдээс талархал

хүлээж байна. 2021 оны 2 дугаар сард олон нийтэд танилцуулагдсан Ард Аппын 4.0 хувилбарт АрдШопын энэхүү шинэ мобайл хувилбар бүрэн холбогджээ.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хэрэглэгчид онлайн худалдааг илүү ихээр ашиглах болсон бөгөөд өнгөрсөн оны 11-12 саруудад Засгийн газраас цар тахалтай тэмцэх зорилгоор хэрэгжүүлсэн хөл хорионы дэглэм нь цахим худалдааны салбарыг өсгөх маш том нөлөөлөл байлаа. 12 дугаар сард АрдШоп онлайн дэлгүүрийн захиалгын тоо 2019 оны мөн сартай харьцуулахад 384 хувиар өссөн бөгөөд хэрэглэгчид ном, өдөр тутмын өргөн хэрэглээний

бүтээгдэхүүнээс гадна цахилгаан хэрэгсэл, дасгалын төхөөрөмж зэрэг өндөр үнийн дүнтэй худалдан авалтуудыг тогтмол хийн үйлчлүүллээ. Цар тахлын нөлөөгөөр Монгол хэрэглэгчдийн цахим хэрэглээ нэмэгдэж, худалдан авалтын зан төлөвт эргэлт буцалтгүй өөрчлөлт орсон гэж бид үзэж байна. Бизнес эрхлэгчдийн хувьд цахим борлуулалтын суваг, хүргэлтийн үйлчилгээ нь стратегийн хувьд хамгийн өндөр ач холбогдолтой чадамж боллоо. АрдШоп нь бизнес эрхлэгчдэд тэрхүү цахим борлуулалтын сувгийг нээж өгөх, Монгол Шуудангийн хүргэлт, АрдКойн лоялти хөтөлбөрийг давуу талаа болгосон шилдэг түнш юм.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



DAX - Виртуал Хөрөнгийн Бирж (DAX.mn)


2020 оны 12 сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн Виртуал Хөрөнгийн Бирж болох DAX (Digital Assets Exchange) дээр одоогоор АрдКойн (ALP),

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны токен, биткойн (BTC), этериум (ETH) зэрэг бүтээгдэхүүнүүд 24/7 арилжаалагдаж байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



АРИЛЖААНЫ МЭДЭЭ



Үндэсний Хувьчлалын Сан (MSE: ХОС)

2019 онд байгуулагдсан Монголын анхны хаалттай хамтын Хөрөнгө Оруулалтын Сан болох Үндэсний Хувьчлалын Сан нь 2020 онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс 4.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Сангийн нэгж эрхэд хөрөнгө оруулалт хийснээр мэргэжлийн багаар

хөрөнгө оруулалтын менежмент хийлгэж, улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож мөн дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийж өгөөж хүртэх боломжтой.


НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

MSE: ХОС	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Өдрийн дундаж арилжаа	Нийт арилжааны дүн	Арилжигдсан тоо ширхэг
2020/01/01 - 2020/12/31	₮100	₮114.04	₮100	₮108.63	8.63%	₮6,981,621	₮321,154,588	2,998,594
2020/12/31 - 2021/03/31	₮108.63	₮259.7	₮107	₮259.7	139.07%	₮21,394,392	₮1,305,057,932	7,163,109

	2020	2021 У1		2020	2021 У1
Нийт нэгж эрхийн тоо	2,451	3,792	Хаалтын үнэ	₮108.63	₮259.7
Нийт хувьцааны тоо	50,000,000	50,000,000	Цэвэр хөрөнгийн үнэ цэн	₮104.75	₮161.24
Зах зээлийн үнэлгээ	₮5,431,500,000	₮12,985,000,000			



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ



Монгол Шуудан

2020 оны онцлох үйл явдал

- Ялган боловсруулах төв байгуулах төсөл
- Орон нутгийн салбарын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх
- Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх төсөл
- E-Mongolia төрийн үйлчилгээний хүргэлт

УЛС ХООРОНДЫН

шуудангийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

САНХҮҮГИЙН

үйлчилгээг эхлүүлэх, нэр төрлийн нэмэгдүүлэх

ЛОГИСТИК, ТРАНЗИТ

үйлчилгээг өргөжүүлж дэд бүтцийг бий болгох

СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫГ

сайжруулах, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны тайлан

Цар тахал дэгдэж, хөл хорио тогтоосон үед Монгол Шуудан нь ажиллах үеийн бэлэн байдлыг хангаж ажилласан бөгөөд урьдчилсан сэргийлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэм, журмыг чанд мөрдөж, шуудан захиалга, дуудлагаар хүргэлт хийх үйлчилгээг үзүүллээ. 2020 оны эцсийн байдлаар нийт 980 ажилтантай болсон бөгөөд үүнээс 520 нь хөдөө орон нутагт, 460 нь Улаанбаатар хотын салбаруудад ажиллаж байна.

Дотоод шуудангийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх ажлын хүрээнд гараас гарт хүргэлтийн үйлчилгээг сайжруулах, хурдасгах зорилгоор шинэ автомашин авч, хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэв. Мөн хүргэлтийн бүтцийг хялбарчилж, үйлчилгээний систем, хүргэгчийн аппыг сайжруулж хүргэлтийн захиалгыг www.mydelivery.mn сайтаар авч эхэлсэн бөгөөд E-Mongolia системийн захиалгыг шуудангаар

хүргэх үйлчилгээг, их дээд сургуулиудтай хамтран диплом хүргэлтийн үйлчилгээг, захиалгат хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн. Хот хоорондын тээврийн үйлчилгээг өргөжүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулалт хийж хүчин чадлаа нэмснээр цар тахалтай үед халдвар хамгааллыг сахиж бүх аймаг, алслагдсан дүүргүүдэд 7 хоногт 1-4 удаагийн тогтмол хүргэлт хийсэн.

Улс хоорондын шуудангийн сүлжээний ашиглалтыг цар тахалтай үед тасралтгүй, найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд тусгай үүргийн болон карго нислэгээр гадаад шуудан солилцох горимд шилжүүлсэн. Мөн транзит шуудангийн хэвийн үйл ажиллагааг хангаж агаарын болон төмөр замын тээврийг зохион байгууллаа. Улс хоорондын шуудан ялган боловсруулах төвийн нээлтийг хийсэн бөгөөд дэлхийн шуудан холбооны чанарын сангийн санхүүжилтээр “Улс хоорондын ялган боловсруулах төвөөс салбар хоорондын шуудангийн хүргэлтийг сайжруулах”, “Улс хоорондын шуудангийн мэдээллийг цахимаар бүртгэх, дамжуулах, солилцох” төслүүдийг хэрэгжүүлсэн. Дэлхийн шуудан холбооны буухиа шуудангийн үйлчилгээний (Express Mail Service) салбар нээж үйл ажиллагаагаа сурталчлахаас гадна гадаад шуудангийн үйл ажиллагааг зах зээлд таниулах компанит ажлыг

зохион байгууллаа. Буухиа шуудангийн чанарын үзүүлэлтээр Дэлхийн шуудан холбооны гишүүн 198 орноос шалгарч “Шилдэг хэрэглэгчийн үйлчилгээ”-ний шагналыг 2 дахь удаагаа хүртлээ.

Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний EuroGiro олон улсын байгууллагад нэгдэж, Ард Кредит ХК-тай хамтран олон улсын шуудангийн дэд бүтэц, сүлжээг ашиглан мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд анхны гүйлгээг Ковид-19 цар тахлын эсрэг хандивласан юм. Цаашид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн шуудан холбооны санхүүжилтээр санхүүгийн үйлчилгээний стратеги боловсруулах төслийг хэрэгжүүлж байна.

Ажлын онцгой нөхцөл байдалд хэрэглэгчдэдээ илүү хүртээмжтэй байх зорилгоор цахим сүлжээг голчлон ашиглаж хэрэглэгчдэдээ мэдээ, мэдээллийг цаг тухайд хүргэж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тогтмол хянаж байв. Мөн цахим шилжилтийн ажлын хүрээнд компанийн вэбсайтыг шинэчилж, MongolPost App-ын хөгжүүлэлтийг хийж эхэлсэн.

Бидний ойрын ирээдүй

Он гарсаар бид банкинд хөрөнгө оруулах ажилдаа шамдан орсон бөгөөд 2021 онд арилжааны банкны стратегийн түншлэлийг байгуулж, банкны хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Богд Банкны IPO хийх мандатыг авсан болно. Мөн тус банкыг нээлттэй болохоос нь өмнө стратегийн түншлэлийн гэрээ байгуулж, 11.7 хувьд нь хөрөнгө оруулах тохиролцоог хийв.

УИХ-аас Виртуал Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгчийн тухай хууль батлагдсанаар уг салбарын хувьд томоохон алхам болох бөгөөд Digital Assets Exchange буюу dax.mn-ы хувьд үйл ажиллагаагаа

улам өргөжүүлэх боломж бүрдэх юм. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан Сэндбоксын журмын дагуу зарим ажлуудыг туршилтын журмаар эхлүүлэхээр зэхэж байна.

Ард Санхүүгийн Нэгдлийн 100 хувь хөрөнгө оруулалттай Ард Холдингс Интернэшнл компани нь Торонтогийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болох ажлаа эхлүүлж, энэ чиглэлээр ихээхэн туршлагатай Канадын зөвлөх үйлчилгээний компанитай хамтын ажиллагаа эхлүүлэв.



- Алтны салбарын тэргүүлэгч Степ Голд компанийн давхар бүртгэлийг хийж, Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO хийх мандатыг Ард Секюритиз авч, ажилдаа орсон бөгөөд II улиралд багтаж IPO хийхээр шамдан ажиллаж байна.

- Богд Банкнд IPO хийх мандатыг авахаас гадна IPO-ны өмнөх хөрөнгө оруулалтыг хийхээр болов.

- Гадны банкинд хөрөнгө оруулах ажлаа эхлүүлсэн ч цар тахал болон бүс нутгийн тогтворгүй байдлаас шалтгаалан хойшлогдож болзошгүй байна.

- Технологи эрхэлсэн захиралтай болох ажил маш өндөрт эрэмбэлэгдэж байна.

- Шинэ хөрөнгө оруулагчдыг татан оруулснаар компанийнхаа цар хүрээг илүү өргөжүүлэхэд чиглэн ажиллана.

- Төвлөрсөн бус санхүүжилтийн (DeFi) технологийг бүрэн эзэмших ажилд анхаарал төвлөрүүлэн ажиллах болно.

- Санхүүгийн холбогдолтой мэдээллүүдийг цаг тухайд нь үнэн шударгаар хүргэн, сэтгүүлзүйн салбарт эрүүл өрсөлдөөн бий болгож, чанартай бүтээл нийлүүлэх Медиа Групп үүсгэн байгуулахыг зорьж байна.

- Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банктай хамтран ажиллаж, “Making Finance Work for Women” эмэгтэйчүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлыг дэмжин ажиллахаар болов.

- Өөрийн гэсэн үнэт цаасны биржтэй болж, Монголын хөрөнгийн зах зээлд оруулах хувь нэмрээ нэмэгдүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

- Цар тахлын улмаас эдийн засаг саармагжсан үед нийгэмд тустай төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хандив тусламж үзүүлэх тал дээр илүү анхаарч ажиллана.

- Давтагдашгүй бүтээлийг блокчэйн дээр бүртгэдэг NFT технологийг Монголд анхлан нэвтрүүлэхээр

судалж, хэрэгжүүлэхэд бэлтгэж байна.

- АрдКойныг Этериумын шинэ протокол руу шилжүүлж, Bittrex Global дээр арилжаалагдаж эхлэхээс гадна, олон улсын хамгийн том биржүүд болох Binance SmartChain дээр давхар бүртгүүлнэ.

- Орон нутагт суугаа иргэддээ санхүүгийн хүртээмжтэй мэдлэгийг түгээх үндэсний хэмжээний хөтөлбөр зохион байгуулна.

- Компанийнхаа үйл ажиллагааг Гадаадад суугаа Монголчууддаа хүргэх ажлуудыг идэвхжүүлнэ.

2021 он **Эхний улирлын гол үйл явдал**

Юникорн мэндлэв

Ковид-19 цар тахлын нөлөө нийгэм эдийн засгийн амьдралд гүн гүнзгий нөлөө үзүүлсээр байгаа бөгөөд өвчний тархалт намжихгүй байгаатай холбогдуулан Засгийн Газраас хүн амын хөдөлгөөн, бизнесийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалтыг тавьсаар ирлээ. Улсын Онцгой Комисс вакцинжуулалтын ажлыг шат дараатай эхлүүлж, оны II улиралд хүн амаа бүрэн хамруулахаар ажиллаж байна.

Эрх баригчдаас санаачилсан банкны реформын хүрээнд Банкны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орж, батлагдсанаар нэг хувьцаа эзэмшигчийн дээд хязгаарыг 20 хувиар тогтоож, арилжааны банкууд 2 жилийн хугацаанд олон нийтэд нээлттэй арилжаалагдах шаардлага тавигдав. Ард Санхүүгийн Нэгдлийн зүгээс олон түмнийг уриалж, банкинд хөрөнгө оруулах ажлаа эхлүүлсэн бөгөөд Богд банктай стратегийн түншлэлийн санамж бичгийг үзэглэж, IPO хийх мандатыг аваад зогсохгүй, өөрийн охин компани болох Ард Холдингс Интернэшнлээр дамжуулан тус банкинд хөрөнгө оруулах болов.

2021 оны эхний улирлын эцсийн байдлаар Ардын тусдаа баланс 437 тэрбум төгрөгт хүрэв. Бид нийт 14.6 тэрбумын ашигтай ажилласан бол өөрийн хөрөнгө маань 377 тэрбумд хүрлээ. Зах зээлийн капитализац 290 тэрбумтай байгаа хэдий ч Ардын үнэлгээ 408 тэрбум төгрөгт хүрсэн гэж бид дүгнэж байна. Үүнд манай нийт дэлгэрэнгүй цэвэр ашиг

304 тэрбум болсон нь голлон нөлөөлөв. Бидний хийсэн эл дотоод үнэлгээгээр AARD 14,266 төгрөгт хүрчээ.

Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 66 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэнээс 51 тэрбум буюу 77 хувь нь Ардын холбоотой компаниудын арилжаа байсан бол AARD арилжаа дангаараа 45.8 хувийг бүрдүүлсэн байна. 83.5 тэрбумын арилжаа хийсэн Ард Секюритиз мэдээжийн хэрэг хамгийн идэвхтэй үнэт цаасны компани байсан юм. Ард Секюритизын ТУЗ-ийн даргаар Э. Амарбаясгалан ажиллаж эхэлсэн бөгөөд Степ Голд давхар бүртгэл болон Богд Банкны IPO-г оны эхний хагаст амжуулахаар ажиллаж байна. Компанийн хувьцааны үнэ 2021 он гарсаар өдөр алгасахгүй шахам өссөөр ирсэн ба үр дүнд нь Ард Санхүүгийн Нэгдэл Монголын Хөрөнгийн Бирж дээрх хамгийн том компаниудын нэг болж, АПУ болон Таван Толгойн араас 3-т жагсав.

Ардын хувьцаа эзэмшигчид давхардсан тоогоор 57,940-д хүрсэн байна. Энд ХОС-ын хөрөнгө оруулагчид болон DAX дээрээс үнэт цаасны токен эзэмшигчид орсон болно.

DAX дээр нийт 4.8 тэрбум АрдКойны арилжаа явагдсан байна. Ард Апп хэрэглэгчдийн тоо 1.2 саяд хүрснээр бид үндэсний хамгийн том хэрэглэгчийн суурьтай компани болж чадлаа.

Цагаан сарын Насны Мялаалга, хүүхэд бүрт 77 АрдКойн, харилцагчийн урамшуулал болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн олон ажлын үр дүнд нийт 82.4 сая АрдКойн тараагдсан байна.

Оны эхний улиралд бид нийт 88 ажлын байрыг бий болгоод байна.

Зохицуулалтын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, АрдКойн, хувьцааны үнийн өсөлт дээр зохих тайлбаруудыг хийсэн бол Кripto Үндэстнийг

Булган Ундрага компани руу шилжүүлснээр тэдний арилжааг эхлүүлэв. Мэдээллийн технологи, харилцааны төвийг сайжрууллаа. Ард Лизинг болон Ард Пропертиз компаниудын үйл ажиллагаа идэвхжив. Гацуурт ХХК-ийн нийт 40 тэрбумын бондыг бид хаалттай хүрээнд гаргаж, санхүүжүүлэв. Манай хамгийн том хувьцаа эзэмшигч Хишиг Арвин өөрийн хувьцааны талыг Ард Кредит, Ард Даатгалын хувьцаагаар сольж, үлдсэнийг нь бэлэн мөнгөөр компанид худалдах санал тавьж, холбогдох гэрээнүүдийг байгуулан ажиллаж байна.

Гол охин компаниудын онцлох үйл явдал:

- Ард Кредит нийт зээлийн багцаа 25 хувиар өсгөж 25 тэрбумд хүргэв. 39 мянган зээлдэгчтэй болсон тус компани 2.4 тэрбум төгрөгийн цэвэр ашиг, 19.8 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй ашигтай ажиллав.
- Ард Даатгалын хөрөнгө 35 тэрбумд хүрч 6.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Тус компанийн ТУЗ-өөс 1 тэрбумын ашиг хуваарилах шийдвэр гаргав.
- Ард Лайфын нийт хөрөнгө 3 нугарч 67 тэрбум төгрөгт хүрэв.

- Виртуал Хөрөнгийн Бирж болох DAX үйл ажиллагаагаа эхэлснээс хойш олон түмний таашаалд нийцэж, 3 сарын дотор 600 мянган харилцагчтай болж чадсанаас гадна арилжааны шимтгэлээрээ асар өндөр ашиг үйлдвэрлэж эхлэв.
- Ард Секюритизын хувьд зах зээл дээрх өөрийн манлайллыг бататгаж, хоёр IPO-ны мандатыг авч чадав.
- Үндэсний Хувьчлалын Сангийн үйл ажиллагаа тасралтгүй өсөн өргөжихийн хэрээр түүний зах зээл дээрх үнэлгээ хамгийн дээд түвшин болох 300 төгрөгийн босгыг эвдэв.

Үнэлгээ

(Сая төгрөг)	2019	Эзэмшил	2020	Эзэмшил	2021 У1	Эзэмшил
Стратегийн хөрөнгө оруулалт	67,288		67,450		244,676	
Монгол Шуудан (MSE: MNP)	18,066	25.50%	17,689	23.68%	39,965	23.69%
Ард Даатгал (MSE: AIC)	13,356	66.80%	13,108	65.54%	18,335	50.40%
Ард Кредит (MSE: ADB)	13,973	60.80%	14,080	61.25%	32,243	46.02%
Ард Секюритиз	2,305	100.00%	2,305	100.00%	19,489	100.00%
Ард Менежмент	365	100.00%	1,265	100.00%	10,859	100.00%
Ард Актив	119	10.00%	99	9.50%	319	9.46%
Ард Лайф	11,426	100.00%	11,426	100.00%	51,009	100.00%
Ард Бит (DAX орсон)	200	100.00%	0	100.00%	38,923	100.00%
Ард Лизинг	0	100.00%	0	100.00%	8,768	100.00%
ТэнГэр Системс (АрдШоп орсон)	1,154	100.00%	1,154	100.00%	7,502	100.00%
Ард Холдингс Интернэшнл	6,325	100.00%	6,325	100.00%	17,264	100.00%
Тактикийн хөрөнгө оруулалт	967		50		23,255	
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)	0		3	0.05%	4	0.03%
Булган Ундрага (MSE: BUN)			28	32.89%	230	32.89%
Крипто Үндэстэн	950	32.40%	0		0	
Бусад санхүүгийн хэрэгсэл	17		19		23,021	
Бусад хөрөнгө	(8,601)		(8,263)		140,281	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	769		9,407		149,972	
Бэлэн мөнгө	43		101		616	
Бусад цэвэр хөрөнгө	(9,414)		(17,771)		(10,307)	
Нийт үнэлгээ	59,653		59,237		408,212	
Хувьцааны тоо	27,175,629		27,175,629		28,614,263	
Нэгж хувьцааны үнэлгээ	2,195		2,180		14,266	


Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

MSE: AARD	Нээлт	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт	Өдрийн дундаж арилжаа	Нийт арилжааны дүн	Арилжигдсан тоо ширхэг
2020/01/01 - 2020/12/31	₮1,700.00	₮1,800.00	₮1,002.00	₮1,758.00	3.41%	₮18,080,059.05	₮4,411,534,408.00	3,051,370
2021/01/01 - 2021/03/31	₮1,750.00	₮12,200.00	₮1,600.00	₮10,180.00	x5.8	₮390,775,291.90	₮23,837,292,803.00	4,666,940

	2019	2020	2021 У1		2019	2020	2021 У1
Хувьцаа эзэмшигчдийн тоо	4,063	4,523	13,730	Хаалтын үнэ	₮1,766	₮1,758	₮10,180
Нийт хувьцааны тоо	28,614,263	28,614,263	28,614,263	P/E - Үнэ/Ашиг	-	-	30.85
Зах зээлийн үнэлгээ	₮50,532,788,458	₮50,303,874,354	₮291,293,197,340	P/B - Үнэ/Дансны үнэ	0.89	0.90	0.77





Мянган төгрөгөөр		
	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43,236	100,958
Дансны болон бусад авлага	4,912,768	1,685,343
Бусад санхүүгийн хөрөнгө	416,506	18,737
Бараа материал	6,231	2,112
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	551,327	1,243,564
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,930,068	3,050,714
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	642,006	466,025
Биет бус хөрөнгө	3,261,572	8,941,367
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	440,433
Урт хугацаат хөрөнгө оруулалт	68,238,169	67,481,313
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	72,141,747	77,329,138
Нийт хөрөнгө	78,071,815	80,379,852
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	2,613,677	4,552,360
Богино хугацаат зээл	1,082,465	1,147,287
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	-	11,958,106
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	40,096	349,718
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,736,238	18,007,471

Санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр	3,070,863	3,405,208
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	262,390	379,093
Урт хугацаат зээл	2,236,039	408,752
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	12,183,955	2,347,232
Урт хугацаат өр төлбөрийн дүн	17,753,247	6,540,285
Өр төлбөрийн нийт дүн	21,489,485	24,547,756
Эздийн өмч		
Өмч-хувьцаат	28,590,335	28,590,335
Халаасны хувьцаа	(1,414,706)	(1,414,706)
Дахин үнэлгээний нөөц	24,105,478	27,284,096
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	5,287,424	1,358,572
Эздийн өмчийн дүн	56,582,330	55,832,096
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	78,071,815	80,379,852

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2019	2020
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	346,333	688,461
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	879,944	303,915
Ногдол ашгийн орлого	537,157	1,311,736
Хөрөнгө оруулалтын багцын хүүний орлого	302,225	29,984
Нийт хөрөнгө оруулалтын орлого	2,065,659	2,334,096
Бусад орлого	788,556	916,740
Борлуулалт, маркетингийн зардал	1,625,924	271,381
Ерөнхий ба удирдлагын зардал	3,293,038	3,183,791
Санхүүгийн зардал	1,476,353	2,876,353
Бусад зардал	896,380	785,887
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(20,036)	(170,140)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(34,430)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,491,946)	(4,036,716)
Орлогын татварын зардал (өгөөж)	84,204	(2,041)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,576,150)	(4,034,675)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц	9,348,676	385,328
Виртуал хөрөнгийн үнэлгээний нөөц	675,736	3,849,693
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн	10,024,412	4,235,021
Нийт дэлгэрэнгүй ашиг	5,448,262	200,346
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(0.21)	(0.15)

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримт -лагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,879,653	(160,216)	9,929,061	14,081,066	13,799	24,767,270	50,510,633
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	10,956	10,956
Залруулсан үлдэгдэл	1,879,653	(160,216)	9,929,061	14,081,066	13,799	24,778,226	50,521,589
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(4,576,150)	(4,576,150)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	10,024,412	-	-	10,024,412
Өмчид гарсан өөрчлөлт	26,710,682	(1,254,490)	(9,929,061)	-	-	(14,914,652)	612,479
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	24,105,478	13,799	5,287,424	56,582,330
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	-	-	(4,034,675)	(4,034,675)
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	-	4,235,021	-	-	4,235,021
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(950,580)	(950,580)
Дахин үнэлгээний нөөцөөс хэрэгжсэн дүн	-	-	-	(1,056,403)	-	1,056,403	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	28,590,335	(1,414,706)	-	27,284,096	13,799	1,358,572	55,832,096

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2019	2020
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Татварын өмнөх ашиг	(4,491,946)	(4,036,716)
Тохируулга:		
Элэгдлийн зардал	323,745	179,194
ХЭ-Түрээсийн ашиглах эрх	-	293,622
Хорогдлын зардал	4,722	17,936
Бодит үнэ цэнийн тохируулга	10,024,412	(428,143)
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц	(7,299,818)	3,178,618
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз)/гарз	34,430	-
Хойшлогдсон татварын нөлөөлөл	995,785	321,359
Энгийн хувьцаа	16,781,621	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	1,056,404
Зарласан ногдол ашиг	-	(950,579)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны орлого	16,372,952	(368,307)
Ажлын капиталын өөрчлөлт		
Дансны авлагын (өсөлт) бууралт	(2,072,416)	3,227,425
Бусад санхүүгийн хөрөнгө (өсөлт) бууралт	6,639,120	397,769
Бараа материалын (өсөлт) бууралт	30,133	4,119
Урьдчилж гарсан зардлын (өсөлт) бууралт	279,146	(692,237)
Дансны өглөгийн өсөлт (бууралт)	2,271,678	1,938,683
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	23,520,612	4,507,452
Орлогын татварын зардал	33,835	15,027
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,554,447	4,522,479

Мөнгөн гүйлгээний **тайлан** (үргэлжлэл)

2020 У1 – Санхүүгийн үзүүлэлт аудитлагдаагүй болно.

Мянган төгрөгөөр	2019	2020
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн зарлагын дүн		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(28,241)	(3,212)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(3,251,689)	(5,697,731)
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(17,127,632)	1,184,998
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	4,817,832	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	(307,730)
Халаасны хувьцаа	(1,254,490)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,844,220)	(4,823,674)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	-	-
Мөнгөн орлогын дүн		
	10,851,969	13,280,932
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,851,969	13,280,932
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн		
	(17,530,382)	(12,922,014)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(2,929,171)	(12,922,014)
Санхүүгийн түрээсийн өглөг	302,486	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	(14,903,697)	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
	(6,678,413)	358,918
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
	31,814	57,722
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	11,423	43,236
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
	43,236	100,958



2020

Хүчтэй. Хамтдаа.